



НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ



**“НИЙСЛЭЛИЙН СУРГУУЛИЙН БАГА АНГИЙН СУРАГЧДЫН
ГАРЫН ЭРҮҮЛ АХУЙН МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДАЛ”**

(ТҮРГЭВЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН)

Улаанбаатар хот

2024 он

Захиалагч байгууллага

НҮБ-ын Хүүхдийн сан

Хэрэгжүүлэгч байгууллага

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

Хамтран ажилласан байгууллага

Нийслэлийн БЗД-ийн 84, 33 дугаар сургууль

Нийслэлийн СХД-ийн 76, 153 дугаар сургууль

Удирдлагын баг

С.Өнөрсайхан, ХУ-ны доктор, дэд профессор, НЭМҮТ-ийн Захирал

С.Цэгмэд, АУ-ны доктор, НЭМҮТ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга

И.Болормаа, АУ-ны доктор, ОЭМНҮА-ны Зөвлөх

Л.Нямсүрэн, НЭМ-ийн магистр, ОЭМНҮА-ны дарга

С.Гэрэлмаа, АУ-ны магистр, ЭМДМА-ны дарга

Мэдээлэл цуглуулсан үнэлгээний баг

Х.Бямбасүрэн, БСУ-ны магистр, ЭМДМА-ны мэргэжилтэн

Р.Энхбат, НЭМ-ийн магистр, ЭМДМА-ны мэргэжилтэн

Г.Мөнхнаран, ЭМДМА-ны мэргэжилтэн

Б.Идшинхорлоо, ЭМДМА-ны мэргэжилтэн

Д.Отгонцэцэг, ЭМДМА-ны мэргэжилтэн

Б.Нарангэрэл, ЭМДМА-ны мэргэжилтэн

Г.Бадамцэцэг, ЭМДМА-ны мэргэжилтэн

Ч.Анаргоо, ЭМДМА-ны мэргэжилтэн

Р.Оюунгэрэл, ЭМДМА-ны мэргэжилтэн

Ц.Пүрэвсүрэн, СУА-ны мэргэжилтэн

Ж.Энхбат, СУА-ны мэргэжилтэн

Ч.Мягмардорж, ОЭМНҮА-ны ЭША

Х.Жавхлан, ОЭМНҮА-ны ЭША

Н.Мягмаржаргал, ОЭМНҮА-ны ЭША

Э.Өнөрзаяа, ОЭМНҮА-ны ЭША

Н.Энхнаран, ОЭМНҮА-ны ЭША

С.Гантогтох, АШУҮИС-ийн оюутан

Статистик боловсруулалт

С.Цэгмэд, АУ-ны доктор, НЭМҮТ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга

Х.Бямбасүрэн, БСУ-ны магистр, ЭМДМА-ны мэргэжилтэн

Тайлан бичсэн

Х.Бямбасүрэн, БСУ-ны магистр, ЭМДМА-ны мэргэжилтэн

Р.Энхбат, НЭМ-ийн магистр, ЭМДМА-ны мэргэжилтэн

Г.Мөнхнаран, ЭМДМА-ны мэргэжилтэн

Б.Идшинхорлоо, ЭМДМА-ны мэргэжилтэн

Р.Оюунгэрэл, ЭМДМА-ны мэргэжилтэн

Хянан тохиолдуулсан

С.Өнөрсайхан, ХУ-ны доктор, Дэд профессор, НЭМҮТ-ийн Захирал

С.Цэгмэд, АУ-ны доктор, НЭМҮТ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга

И.Болормаа, АУ-ны доктор, ОЭМНҮА-ны Зөвлөх

И.Туяажаргал, ХУ-ны доктор, ШУБИА-ны ЭШАА

Л.Нямсүрэн, НЭМ-ийн магистр, ОЭМНҮА-ны дарга

С.Гэрэлмаа, АУ-ны магистр, ЭМДМА-ны дарга

Тайлан орчуулсан

Ч.Анаргоо, ЭМДМА-ны мэргэжилтэн

ГАРЧИГ

Үр дүнгийн товч хураангуй.....	5-7
Хүснэгтийн жагсаалт.....	8
Зургийн жагсаалт.....	9-10
БҮЛЭГ 1. Ерөнхий хэсэг... ..	11-12
БҮЛЭГ 2. Материал арга зүй.....	13-14
БҮЛЭГ 3. Үр дүн.....	15-52
БҮЛЭГ 4. Ерөнхий дүгнэлт, зөвлөмж.....	53
Хавсралт 1.....	54
Хавсралт 2.....	55-57

ҮР ДҮНГИЙН ТОВЧ ХУРААНГУЙ

Нийслэлийн бага ангийн сурагчдын гарын эрүүл ахуйн мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх түргэвчилсэн үнэлгээг НҮБХС-ийн дэмжлэгтэйгээр Нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдыг хамруулан нас, хүйсээр харьцуулан судалж, нотолгоонд суурилсан мэдээллээр бодлого тодорхойлогч нарыг хангах, зөвлөмж боловсруулах зорилго бүхий нэг агшингийн загвараар түргэвчилсэн үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

Үнэлгээнд Баянзүрх дүүргийн 84, 33, Сонгинохайрхан дүүргийн 76, 153 дугаар сургуулийн 1-5 дугаар ангийн 5-11 насны 515 сурагчид хамрагдсан бөгөөд хүйсийн хувьд 51.7% хөвгүүд, 48.3% охид байв. Сурагчдын дундаж нас 8.04, үүнээс хөвгүүд 8.09, охидууд 7.98 бөгөөд 58.3% орон сууцанд, 40.8% гэр хороололд, 1.0% дотуур байранд амьдардаг байна.

Сурагчдын дийлэнх (92.6%) хоол идэхийн өмнө гар угаах хэрэгтэй гэсэн зөв мэдлэгтэй байгаа боловч сургууль дээрээ хоол идэхийн өмнө 27.9% гараа тогтмол угаадаг байна. Гар угаах дарааллын талаарх зөв мэдлэгийн түвшинг насаар харьцуулахад 8 настай сурагчдын дунд (78.8%) хамгийн өндөр, 10 настай сурагчдын дунд хамгийн бага (65.1%) үзүүлэлттэй байна. Сурагчдын 96.1% гараа бүрэн угаахад саван шаардлагатай гэсэн зөв мэдлэгтэй байгаа боловч 57.8% сургууль дээр саван байдаггүй гэж хариулсан байна.

Үнэлгээнд хамрагдсан сурагчдын 45.4% гараа 30-60 секундын хугацаанд угаах ёстой гэсэн зөв мэдлэгтэй. Хүйсээр харьцуулан авч үзвэл хөвгүүд (49.2%) охидуудаас (41.4%) илүү, насаар авч үзвэл 5 настай сурагчдын дунд 30-60 секунд угаах ёстой гэсэн зөв мэдлэг хамгийн өндөр (61.5%) үзүүлэлттэй байна. Суралцагчдын “Дэлхийн гар угаах өдөр”-ийг мэддэг эсэхийг үнэлэхэд 94.8% огт мэдэхгүй, үлдсэн 5.2% тухайн өдрийн талаар сонсож байсан боловч хэдэн сард болдог талаар мэдэхгүй байна. Дэлхийн гар угаах өдрийг огт мэдэхгүй сурагчдын 69.5% сургуулиас зохион байгуулсан гарын ариун цэврийн талаарх сургалтад хамрагдаж байгаагүй, 62.3% гарын ариун цэврийн талаарх аян болон олон нийтийн үйл ажиллагаанд оролцдоггүй байв. Гар угаахын ач холбогдлын талаар сурагчдын 68.2% зөв мэдлэгтэй бөгөөд нас нэмэгдэх тусам гар угаах талаарх мэдлэг нэмэгдэж байгаа ажиглагдав.

Үнэлгээнд оролцсон 3 сурагч тутмын нэг (72.4%) нь гар угаахад зөвхөн ус байх хангалтгүй, 5 сурагч тутмын 4 (80.2%) нь ханиалгаж, найтаасны дараа гараа угаах шаардлагатай гэсэн зөв бодолтой байв. Сурагчдын 85% бохирдсон гар бусдад халдвар дамжих эрсдэлтэй, 75.9% гараа усаар сайтар угаасан ч саван хэрэглэх шаардлагатай гэсэн зөв хандлагатай байна. Сурагчдын дийлэнх хувь зөв хандлагатай ба хүйсээр харьцуулахад охидууд хөвгүүдээс илүү, нас ахих тусам зөв хандлагатай сурагчид нэмэгдэж байгаа нь ажиглагдав. Харин бохирдсон гараар бусдад халдвар дамжих эрсдэлтэй гэсэн зөв хандлагатай сурагчид өдөрт дунджаар 3-4 удаа гараа угаадаг байна.

Гараа угаахдаа 97.5% саван хэрэглэдэг зөв дадалтай, насаар авч үзэхэд 5-6 насанд хамгийн өндөр буюу 99.8% байв. Харин оролцогчдын 90.9% өглөө тогтмол гараа угаадаг зөв дадалтай, гараа угаахдаа 42.7% 30 секундээс 1 минутын хугацаа зарцуулдаг бол 30.5% 30 секунд хүртэл, үлдсэн 26.8% гар угаахдаа зарцуулдаг хугацаагаа мэддэггүй байна.

Үнэлгээнд хамрагдсан сурагчдын 58.3% сургууль дээрээ гараа угаадаг, гараа угаахдаа 42.1% савандаж, 37.1% зөвхөн усаар угаадаг гэсэн бол огт угаадаггүй 11.1% байна. Сургуулийн ариун цэврийн өрөөнд саван байдаггүй гэж 57.8% хариулсан байв.

Сурагчдын өдөрт гараа угаах дундаж 3.75 удаа байна. Гэр хороололд амьдардаг сурагчдын 55.7%, орон сууцанд амьдардаг сурагчдын 59.7% тогтмол гараа угаадаг байна. Гар угаах дадал, давтамжийг амьдардаг орчинтой харьцуулахад ялгаагүй байна.

Гарын эрүүл ахуй сахих талаар сурталчилгааны материал байдаг эсэхийг тодруулахад сурагчдын 37.1% сургуулийн орчинд, 37.9% ангид байдаг гэж хариулсан байна. Энэ нь анги болон сургуулийн орчинд байдаг мэдээлэл сурталчилгааны материалын хүртээмж ойролцоо түвшинд байгааг илтгэж байна.

Сургуулиас зохион байгуулсан гарын ариун цэврийн талаарх сургалтад сурагчдын 31.5% хамрагдсан байна. Гарын ариун цэврийн талаарх сургалтад хамрагдаж байсан нийт сурагчдын 36.3% гар угаах дарааллыг мэддэг байна. Харин 21.4% гарын ариун цэврийн талаарх аян болон олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байсан байна. Сурагчид гар угаах дарааллыг цэцэрлэгт байхдаа түлхүү сурсан байгаа нь сургуулийн өмнөх боловсролын байгууллагад зөв дадлыг хэвшүүлэх ажлыг хэрэгжүүлэх өндөр үр дүнтэй байгааг харуулж байна.

Сурагчид гарын ариун цэврийн талаарх мэдээ, мэдээллийг ихэнх тохиолдолд эрүүл мэндийн байгууллага, мөн найз нөхөд, гэр бүлээсээ авдаг ойр дотны хүмүүсийн нөлөө их байгааг харуулсан. Гарын ариун цэвэр сахих талаар мэдээ, мэдээллийг ямар хэлбэрээр авбал сонирхолтой талаар сурагчдаас тодруулахад 42.7% эмчээс, 14.8% сургалтаар, тодорхой хувь нь интернэт, видео, анимейшн зэргээс авах сонирхолтой гэж хариулсан. Сурагчид мэргэжлийн эмчийн зөвлөгөө, мэдээлэлд илүү анхаарал хандуулж, өдөр тутамдаа дадал болгох хандлагатай байгаа нь ажиглагдав.

Сургалтад хамрагдсан сурагчдын 30.3% гарыг 30-60 секунд угаах ёстой гэж боддог байна.

Дэлхийн гар угаах өдрийг мэддэггүй сурагчдын 69.5% сургуулиас зохион байгуулсан гарын ариун цэврийн талаарх сургалтад хамрагдаж байгаагүй, 62.3% уг аян болон олон нийтийн үйл ажиллагаанд оролцож байгаагүй байна. Тухайн тэмдэглэлт өдрийг мэдэхгүй байгаа нь энэ чиглэлийн сургалт, олон нийтийг хамарсан аяны үйл ажиллагааны зохион байгуулалт хангалтгүй байгаатай холбоотой байна.

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Нэг түүврийн нэгжээс сонгох сурагчдын тоо, сургууль, дүүргийн байршлаар
- Хүснэгт 2. Зорилтот сурагчид, насны бүлэг ба хүйсээр
- Хүснэгт 3. Хоол хийхийн өмнө гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, насаар
- Хүснэгт 4. Хоол идэхийн өмнө гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, насаар
- Хүснэгт 5. Хоол идсэний дараа гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, насаар
- Хүснэгт 6. Бие зассаны дараа гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, насаар
- Хүснэгт 7. Гар бохирдсон үед гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, насаар
- Хүснэгт 8. Гар бохирдсон үед гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, насаар
- Хүснэгт 9. Гараа угаах дарааллын талаарх мэдлэг, насаар
- Хүснэгт 10. Гараа угаах хугацааны талаарх мэдлэг, насаар
- Хүснэгт 11. Гараа бүрэн угаахад саван шаардлагатай талаарх мэдлэг, насаар
- Хүснэгт 12. Дэлхийн гар угаах өдрийн талаар мэдээллийг авсан эх сурвалж, насаар
- Хүснэгт 13. Гар угаахын ач холбогдлын талаарх мэдлэг, насаар
- Хүснэгт 14. Гар угаахад зөвхөн ус байхад хангалттай эсэх талаарх хандлага, насаар
- Хүснэгт 15. Ханиалгаж, найтаасны дараа гараа угаах шаардлагатай эсэх талаарх хандлага, насаар
- Хүснэгт 16. Бохирдсон гараар бусдад халдвар дамжих эрсдэлтэй эсэх талаарх хандлага, насаар
- Хүснэгт 17. Хэрэв гараа усаар сайтар угаасан бол саван хэрэглэх шаардлагатай эсэх талаарх хандлага, насаар
- Хүснэгт 18. Гараа угаах нь халдварт өвчнөөс сэргийлнэ гэдэгтэй санал нийлж байгаа эсэх талаарх хандлага, насаар
- Хүснэгт 19. Гар угаахдаа саван хэрэглэдэг эсэх дадал, насаар
- Хүснэгт 20. Өглөө гараа угаах дадал, насаар
- Хүснэгт 21. Гараа хэрхэн угаадаг талаарх дадал, насаар
- Хүснэгт 22. Гараа угаахдаа зарцуулдаг хугацаа, насаар
- Хүснэгт 23. Сургууль дээрээ гараа угаах дадал, насаар
- Хүснэгт 24. Сургууль дээр байхдаа гараа хэрхэн угааж цэвэрлэдэг эсэх, шалтгаан, насаар
- Хүснэгт 25. Сургуулийн ариун цэврийн өрөөнд саван байдаг эсэх, насаар
- Хүснэгт 26. Сургууль дээрээ хоол идэхийн өмнө гараа угаах дадал, насаар
- Хүснэгт 27. Сургуулиас зохион байгуулсан гарын ариун цэврийн талаарх сургалтад хамрагдаж байсан эсэх, насаар
- Хүснэгт 28. Сургуулийн орчинд сургалт сурталчилгааны материал байдаг талаар хариулсан байдал, насаар
- Хүснэгт 29. Ангид сургалт сурталчилгааны материал байдаг эсэх, насаар
- Хүснэгт 30. Гарын ариун цэврийн талаарх аян болон олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байсан эсэх, насаар
- Хүснэгт 31. Гарын ариун цэвэр сахих талаарх мэдээллийг хаанаас олж авдаг эсэх насаар, %
- Хүснэгт 32. Гарын ариун цэвэр сахих талаар мэдээллийг ямар хэлбэрээр авбал сонирхолтой талаар насаар, n, %
- Хүснэгт 33. Гарын ариун цэврийн талаарх аян болон олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байсан эсэх, насаар n, %
- Хүснэгт 34. Дэлхийн гар угаах өдрийг мэдэхгүй сурагчид сургалт болон аян, олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байгаагүй сурагчдын харьцуулалт, n, %

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Сурагчдын анги бүлэг, хүйсээр, %
- Зураг 2. Сурагчдын амьдардаг сууцны төрөл, хүйсээр, %
- Зураг 3. Гараа ямар үед угаах ёстой талаарх мэдлэг
- Зураг 4. Хоол хийхийн өмнө гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, хүйсээр, %
- Зураг 5. Хоол идэхийн өмнө гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, хүйсээр, %
- Зураг 6. Сургууль дээрээ хоол идэхийн өмнө гараа угаадаг, %
- Зураг 7. Хоол идсэний дараа гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, хүйсээр, %
- Зураг 8. Бие зассаны дараа гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, хүйсээр, %
- Зураг 9. Гар бохирдсон үед гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, хүйсээр, %
- Зураг 10. Гаднаас гэртээ орж ирсэний дараа гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, хүйсээр, %
- Зураг 11. Гараа угаах дарааллын талаарх мэдлэг, хүйсээр, %
- Зураг 12. Гараа угаах хугацааны талаарх мэдлэг, хүйсээр, %
- Зураг 13. Гараа бүрэн угаахад саван шаардлагатай талаарх мэдлэг, хүйсээр, %
- Зураг 14. Дэлхийн гар угаах өдрийн талаарх мэдлэг, хүйсээр, %
- Зураг 15. Гар угаахын ач холбогдлын талаарх мэдлэг, хүйсээр, %
- Зураг 16. Гарын эрүүл ахуйн талаарх хандлага
- Зураг 17. Гар угаахад зөвхөн ус байхад хангалттай эсэх талаарх хандлага, хүйсээр, %
- Зураг 18. Ханиалгаж, найтаасны дараа гараа угаах шаардлагатай эсэх талаарх хандлага, хүйсээр, %
- Зураг 19. Бохирдсон гараар бусдад халдвар дамжих эрсдэлтэй эсэх талаарх хандлага, хүйсээр, %
- Зураг 20. Хэрэв гараа усаар сайтар угаасан бол саван хэрэглэх шаардлагатай эсэх талаарх хандлага, хүйсээр, %
- Зураг 21. Гараа угаах нь халдварт өвчнөөс сэргийлнэ гэдэгтэй санал нийлж байгаа эсэх талаарх хандлага, хүйсээр, %
- Зураг 22. Гарын эрүүл ахуйн талаарх дадлын асуултуудыг харьцуулан үзэхэд
- Зураг 23. Гар угаахдаа саван хэрэглэдэг эсэх дадал, хүйсээр
- Зураг 24. Өглөө гараа угаадаг эсэх, хүйсээр
- Зураг 25. Гараа хэрхэн угаадаг талаарх дадал, хүйсээр
- Зураг 26. Гараа угаахдаа зарцуулсан хугацаа, хүйсээр
- Зураг 27. Сургууль дээрээ гараа угаах дадал, хүйсээр
- Зураг 28. Сургууль дээр байхдаа гараа хэрхэн угааж цэвэрлэдэг эсэх, шалтгаан, хүйсээр
- Зураг 29. Сургуулийн ариун цэврийн өрөөнд саван байдаг эсэх, %
- Зураг 30. Сургуулийн ариун цэврийн өрөөнд саван байдаг эсэх, хүйсээр
- Зураг 31. Сургууль дээрээ хоол идэхийн өмнө гараа угаах дадал, хүйсээр
- Зураг 32. Сургууль дээрээ гараа угаах дадал, шалтгаанаар, %
- Зураг 33. Гараа угаадаггүй бол шалтгаан, %
- Зураг 34. Сургалт, олон нийтийн үйл ажиллагаанд оролцож байсан эсэх, %
- Зураг 35. Сургуулиас зохион байгуулсан гарын ариун цэврийн талаарх сургалтад хамрагдаж байсан байдал, хүйсээр, %
- Зураг 36. Сургуулийн орчинд сургалт сурталчилгааны материал байдаг талаар хариулсан байдал, хүйсээр, %
- Зураг 37. Ангид сургалт сурталчилгааны материал байдаг талаар хариулсан байдал, хүйсээр, %
- Зураг 38. Гарын ариун цэврийн талаарх аян болон олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байсан эсэх, хүйсээр
- Зураг 39. Гарын ариун цэвэр сахих талаарх мэдээллийг хаанаас олж авдаг эсэх, %
- Зураг 40. Гарын ариун цэвэр сахих талаарх мэдээ, мэдээллийг ямар хэлбэрээр авбал сонирхолтой талаар, %

Зураг 41. Гарын ариун цэврийн талаарх аян болон олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байсан эсэх, хүйсээр, %

Зураг 42. Сургуулиас зохион байгуулсан сургалт, аян олон нийтийн үйл ажиллагаанд оролцож байсан эсэх %

БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

1.1. ҮНДЭСЛЭЛ

Аюулгүй ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн үйлчилгээнд бүх нийтийг хамруулах, гэр, сургууль, эмнэлэг, ажлын байр гээд бүх орчинд шаардлага хангасан усан хангамж, бие засах газар, эрүүл ахуйн нөхцөл бүрдүүлэх гэж Тогтвортой хөгжлийн зорилт 2030-д заасан байгаа ч манай улсад тулгамдсан асуудлуудын нэг хэвээр байна.

Гарын ариун цэврийг сахих энгийн зүйл мэт боловч хөгжиж буй болон өндөр хөгжилтэй орнуудад ч иргэдийн гар угаах дадал хангалтгүй, халдварт өвчин дамжих нэг хүчин хэвээр байна. Гараа тогтмол, зөв угааж хэвших эрүүл мэндээ хамгаалах энгийн, үр дүнтэй арга юм. Гар угаах орчин нөхцөл, дэд бүтцийг бүрдүүлэх, хүүхдэд багаас зөв дадал хэвшүүлэхэд эцэг эх, цэцэрлэг, сургууль, хамт олноороо хамтран ажиллах чухал юм.

Монгол орны газар зүйн 4 бүсийн ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн сурагчдын дунд хийгдсэн эрүүл ахуйн дадлыг тогтоох судалгаагаар хоол идэхийн өмнө

2016 онд нийслэлийн ерөнхий боловсролын 48 болон 65-р сургуулийн сурагчдын гар угаах нөхцөлийг судалсан судалгааны дүнгээс харахад 14.3% гараа савандаж, 34.1% зөвхөн усаар зайлж угаадаг, 51.6% сургууль дээрээ гараа угаадаггүй гэсэн байв. Сурагчдын 60 орчим хувь сургууль дээр саван байдаггүй, 11.5% усгүй байдаг шалтгаанаар гараа угаадаггүй байна. Гар угаахын ач холбогдлын талаар мэдээлэл авч байсан сурагчдын гараа угаах давтамж 13.8% илүү байсан.

Монгол улсын Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоолд жил бүрийн 05 дугаар сарын 05-ны өдрийг хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Гарын эрүүл ахуйн” өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлж, уг тэмдэглэлт өдрийн хүрээнд гарын ариун цэврийг сахих, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн эрүүл мэндийн боловсролыг олгосоор ирсэн.

Нийслэлийн төвийн болон алслагдсан дүүргийн бага ангийн сурагчдын гарын эрүүл ахуйн мэдлэг, хандлага, дадлыг үнэлж, түвшинг дээшлүүлэх зорилгоор COMBI аргачлалуудыг ашиглан эрүүл мэндийн боловсролыг олгож, дадал, хандлага төлөвшүүлэхэд үзүүлж буй нөлөөллийн үйл ажиллагааг төгсгөлийн үнэлгээгээр үнэлж, цаашид хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор энэ судалгааны ажлыг эхлүүлсэн.

1.2. ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Нийслэлийн зарим сургуулийн бага ангийн сурагчдын гарын эрүүл ахуйн мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх

1.3. ЗОРИЛТУУД

1. Нийслэлийн зарим сургуулийн бага ангийн сурагчдын гарын эрүүл ахуйн талаарх мэдлэг, хандлага, дадлыг асуумж боловсруулж үнэлгээ хийх
2. Сурагчдын гарын эрүүл ахуйг сайжруулах талаар зөвлөмж боловсруулах

1.4. СУДЛАХ ЗҮЙЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Мэдлэг** тухайн асуудлын талаарх ойлголт, ойлголтын түвшинг илэрхийлнэ.
2. **Хандлага** тухайн асуудлын талаарх санаа бодол, итгэл үнэмшил, тогтсон үзэл бодлыг илэрхийлнэ.
3. **Дадал** тогтсон мэдлэг, хандлагад тулгуурласан зан үйл, үйл хөдлөлийн илэрхийлэл юм.

1.5. ҮНЭЛГЭЭНИЙ ШИНЭЛЭГ ТАЛ, АЧ ХОЛБОГДОЛ

Нийслэлийн зарим сургуулийн бага ангийн сурагчдын гарын эрүүл ахуйн талаарх мэдлэг, хандлага, дадлын өнөөгийн байдлыг нас, хүйсээр харьцуулан тогтоож, сурагчдын гарын эрүүл ахуйг сайжруулах талаар зөвлөмж боловсруулахад энэхүү үнэлгээний шинэлэг тал, ач холбогдол оршино.

1.6. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

1. Нийслэлийн бага ангийн сурагчдын гарын эрүүл ахуйн талаарх мэдлэг, хандлага, дадлыг тогтоож үнэлгээний тайлан боловсруулсан байна.
2. Үнэлгээний үр дүнгээр сурагчдын гарын эрүүл ахуйг сайжруулах чиглэлээр зөвлөмж боловсруулсан байна.

БҮЛЭГ 2. МАТЕРИАЛ, АРГА ЗҮЙ

Судалгаанд хамрагдсан бага ангийн сурагчдын гарын эрүүл ахуйн талаарх мэдлэг, хандлага, дадлыг тогтоох түргэвчилсэн үнэлгээг аналитик зорилтот бүлэгт суурилсан агшингийн загвараар гүйцэтгэж, мэдээллийг тоон судалгааны аргаар цуглуулав.

2.1. Асуулгын арга

Хүн ам зүйн мэдээлэл, гарын эрүүл ахуйн талаарх одоогийн нөхцөл байдал, мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх асуулга ашиглав.

2.2 Үнэлгээний түүвэрлэлт, түүврийн загвар

Үнэлгээнд Улаанбаатар хотын Сонгинохайрхан (СХД), Баянзүрх (БЗД) дүүргийн ЕБС-ийн 1-5 дугаар ангийн сурагчид хамрагдав.

- Орон сууцны дунд байрлалтай ЕБС-ийн 1-5 дугаар ангийн сурагчид
- Гэр хорооллын дунд байрлалтай ЕБС-ийн 1-5 дугаар ангийн сурагчид

Нийслэлийн төвийн болон алслагдсан 2 дүүргийн 4 сургуулийн 1-5 дугаар ангийн 540 сурагчийг санамсаргүй түүврийн аргаар сонгосон. Түүврийн дизайныг боловсруулахдаа зорилтот бүлгийн түвшинд хүлээн зөвшөөрөгдөхүйц нарийвчлалтай байхаар тооцоолол хийж, тохирох бүлэглэсэн түүврийн аргыг ашиглав. Нийт эх олонлогоос түүвэрлэн авсан хэсгээр төлөөлүүлэн сурагчдын мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлов.

2.3 Түүврийн хуваарилалт

Нэг түүврийн нэгж (кластер)-ээс сурагчдыг сонгохдоо тухайн насны сурагчдын эх олонлогт эзлэх хувьд пропорционалиар тооцов (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Нэг түүврийн нэгжээс сонгох сурагчдын тоо, сургууль, дүүргийн байршлаар

Д/д	Байршил	Сонгогдсон дүүрэг	Сонгогдсон сургууль	Түүврийн хэмжээ /ангийн тоо/	Түүврийн хэмжээ /сурагчдын тоо/
1	Төвийн	БЗД	18-р хороо 84-р сургууль	1, 3, 5 дугаар анги	162
			3-р хороо, 33-р сургууль	2, 4 дүгээр анги	108
2	Алслагдсан	СХД	29-р хороо, 153-р сургууль	1, 3, 5 дугаар анги	162
			9-р хороо, 76-р сургууль	2, 4 дүгээр анги	108
Нийт				10 анги	540

2.4. Үнэлгээний мэдээлэл цуглуулалт

Нийслэлийн СХД, БЗД дүүрэгт үнэлгээний мэдээллийг цуглуулахаар нийт 5 баг ажиллав. Баг бүр 4 үндсэн гишүүн, 1 сургуулийн чиглүүлэн туслагч буюу нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй байв. Сургуулийн чиглүүлэн туслагч санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон сурагчдад үнэлгээ эхлэхээс 1 хоногийн өмнө үнэлгээний зорилго, зорилтыг танилцуулсан зөвшөөрлийн хуудас хүргэж, бичгээр зөвшөөрөл өгсөн оролцогчдыг үнэлгээнд хамруулсан.

2.5. Туршилт үнэлгээ

Туршилт үнэлгээг Логарифм ЕБС-ийн сурагчдад гүйцэтгэв. Үнэлгээний гишүүн бүр 2-3 сурагчаас асуулга ярилцлага авч, мэдээлэл цуглуулж, мэдээллийг дахин нягтлан шалгав.

2.6. Үнэлгээнд хамруулах болон хасах шалгуур

Сонгогдсон сурагчдаас зөвхөн бичгээр зөвшөөрөл өгсөн сурагчдыг оролцуулж, үнэлгээ явагдах үед чөлөөтэй, өвчтэй сурагчдыг үнэлгээнд хамруулаагүй болно.

2.7. Үнэлгээний асуулгын ангилал

1. Хүн ам зүйн мэдээлэл (7 асуулт)
2. Гарын эрүүл ахуйн талаарх мэдлэг (8 асуулт)
3. Гарын эрүүл ахуйн талаарх хандлага (5 асуулт)
4. Гарын эрүүл ахуйн талаарх дадал (11 асуулт)
5. Гарын эрүүл ахуйн талаарх мэдээлэл, сургалт, сурталчилгаа (6 асуулт)

2.8. Мэдээллийн бааз нэгтгэх, нягтлах ажиллагаа

Сурагчдын гарын эрүүл ахуйн талаарх мэдлэг, хандлага, дадлыг тогтоох үнэлгээнд оролцогчдын мэдээллийг Microsoft Excel программд шивж мэдээллийн бааз үүсгэсэн. Нэгтгэсэн мэдээллийг EPIDATA 3.1 программд хөрвүүлж судалгаанд шаардлагатай чухал кодуудыг нягтлан шалгаж баталгаажуулан SPSS 25 программд хөрвүүлэв.

2.9. Үнэлгээний мэдээллийн боловсруулалт

Үнэлгээний мэдээлэл цуглуулалтын дараа тоон мэдээлэл, өгөгдлийг CS Pro программд нэгтгэж, нийцтэй байдал, логик шалгалтыг тооцоолов. Мэдээллийн баазыг түшиглэн шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлалын дагуу статистик боловсруулалт, дүн шинжилгээг SPSS 25 программ хангамж ашиглан дундаж утга, давтамжийн үзүүлэлтээр тооцон үр дүнг (стандарт алдаа, итгэх интервал), бүлгүүдийн (хүйс) ялгааг тодорхойлоход 95 хувийн итгэх хязгаар (95%ИХ)-ын утгуудыг ашиглан гүйцэтгэв.

БҮЛЭГ 3. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

3.1. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ


Нийслэлийн Баянзүрх дүүргийн 84, 33, Сонгинохайрхан дүүргийн 76, 153 дугаар сургуулийн 1-5 дугаар ангийн сурагчдын ам бүлийн тоо, сууцны төрөл, нас, хүйс зэрэг үзүүлэлтүүдийг нэгтгэв.

Үнэлгээнд 1-5 дугаар ангийн 5-11 насны 515 сурагчид хамрагдсан бөгөөд оролцогчдын 51.7% (95%ИХ 47.7-55.9) хөвгүүд, 48.3% (95%ИХ 44.1-52.3) охид эзэлж байв (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Зорилтот сурагчид, насны бүлэг ба хүйсээр

Нас	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	
	н	%	н	%	н	%
5	8	1.6	5	1.0	13	2.5
6	35	6.8	44	8.5	79	15.3
7	53	10.3	54	10.5	107	20.8
8	55	10.7	44	8.5	99	19.2
9	60	11.7	51	9.9	111	21.6
10	54	10.5	51	9.9	105	20.4
11	1	0.2	0	0	1	0.2
Нийт	266	51.7	249	48.3	515	100


Судалгаанд 17.9% (95%ИХ 14.6-21.4) 1 дүгээр, 23.9% (95%ИХ 20.2-27.6) 2 дугаар, 17.5% (95%ИХ 14.2-20.6) 3 дугаар, 23.1% (95%ИХ 19.4-26.9) 4 дүгээр, 17.7% (95%ИХ 14.4-21.3) 5 дугаар ангийн сурагчид тус тус хамрагдав (Зураг 1).



Зураг 1. Сурагчдын анги бүлэг, хүйсээр, %

Үнэлгээнд оролцогчдын 21.9% (95%ИХ 18.4-25.9) 33 дугаар, 25.8% (95%ИХ 21.9-29.1) 76 дугаар, 30.5% (95%ИХ 26.6-34.2) 84 дүгээр, 21.7% (95%ИХ 18.6-25.4) 153 дугаар сургуулийн сурагчид байв.

Сурагчдын дундаж нас 8.04 (95%ИХ 7.91-8.17), үүнээс хөвгүүд 8.09 (95%ИХ 7.91-8.28), охид 7.98 (95%ИХ 7.81-8.15) тус тус байв. Оролцогчдын дийлэнх буюу 58.3% орон сууцанд, 40.8% гэр хороололд, 1.0% дотуур байранд амьдардаг байна (Зураг 2).



Зураг 2. Сурагчдын амьдардаг сууцны төрөл, хүйсээр, %


Сурагчид гэртээ 2-13 ам бүлийн гишүүдтэйгээ амьдардаг ба дунджаар 5.02 (95%ИХ 4.90-5.16) гишүүдтэй айл өрх зонхилж байна.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

- 1) Үнэлгээнд Нийслэлийн ерөнхий боловсролын 4 сургуулийн 1-5 дугаар ангийн 5-11 насны 515 сурагчид хамрагдав. Тэдгээрийн 51.7% хөвгүүд, 48.3% охид байв.
- 2) Үнэлгээнд оролцсон сурагчдын 17.9% 1 дүгээр анги, 23.9% 2 дугаар анги, 17.5% 3 дугаар анги, 23.1% 4 дүгээр анги, 17.7% 5 дугаар ангийн сурагчид хамрагдав.
- 3) Сурагчдын дундаж нас 8.04, үүнээс хөвгүүд 8.09, охид 7.98 байв.
- 4) Нэг өрхөд дунджаар 5.02 хүн ам бүл болон амьдарч, үүнээс 5-11 насны дор хаяж 1-3 хүүхэдтэй айл өрх амьдардаг байв.


3.2. ГАРЫН ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААРХ МЭДЛЭГ

Үнэлгээнд хамрагдсан сурагчдын дийлэнх буюу 99% гар бохирдсон үед гараа угаах ёстой, 62.5% хоол идсэний дараа гараа угаах хэрэгтэй гэсэн зөв мэдлэгтэй байсан бол 25.8% гараа угаах хэрэггүй гэж боддог байна (Зураг 3).



Зураг 3. Гараа ямар үед угаах ёстой талаарх мэдлэг

Сурагчдын дийлэнх буюу 94.8% хоол хийхийн өмнө гараа угаах хэрэгтэй гэсэн зөв мэдлэгтэй, харин 1.2% хэрэггүй, 4.1% мэдэхгүй байна. Хүйсээр харьцуулан авч үзвэл охидууд (95.6%) хөвгүүдээс (94.0%) хоол хийхийн өмнө гараа угаах хэрэгтэй гэсэн зөв мэдлэгийн түвшин 1.6% илүү байв (Зураг 4).




Зураг 4. Хоол хийхийн өмнө гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, хүйсээр, %

Хоол хийхийн өмнө гараа угаах хэрэгтэй эсэх талаарх мэдлэгийн түвшинг насаар харьцуулахад 5 настай сурагчид бүгд мэддэг, 9 настай сурагчид хамгийн бага мэддэг, нас ахих тусам зөв мэдлэгтэй сурагчдын тоо буурч байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Хоол хийхийн өмнө гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, насаар

Нас	Хэрэгтэй		Хэрэггүй		Мэдэхгүй	
	п	%	п	%	п	%
5	13	100	0	0	0	0
6	77	97.5	1	1.3	1	1.3
7	102	95.3	0	0	5	4.7
8	93	93.9	2	2.0	4	4.0
9	102	91.9	2	1.8	7	6.3
10	100	95.3	1	0.9	4	3.8
Нийт	488	94.8	6	1.2	21	4.1

Сурагчдын дийлэнх буюу 92.6% хоол идэхийн өмнө гараа угаах хэрэгтэй гэсэн зөв мэдлэгтэй, харин 3.3% хэрэггүй, 4.1% мэдэхгүй байна. Хүйсээр харьцуулан авч үзвэл охид (94.4%) хөвгүүдээс (91%) хоол хийхийн өмнө гараа угаах хэрэгтэй гэсэн зөв мэдлэгийн түвшин 3.4% илүү байв (Зураг 5).



Зураг 5. Хоол идэхийн өмнө гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, хүйсээр, %


Хоол идэхийн өмнө гараа угаах хэрэгтэй эсэх талаарх зөв мэдлэгийн түвшинг насаар харьцуулахад 9 настай сурагчдын дунд хамгийн өндөр (96.4%) 5 настай сурагчдын дунд хамгийн бага (76.9%), нас ахих тусам зөв мэдлэгтэй сурагчдын тоо нэмэгдэж байгаа нь ажиглагдав (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Хоол идэхийн өмнө гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, насаар

Нас	Хэрэгтэй		Хэрэггүй		Мэдэхгүй	
	п	%	п	%	п	%
5	10	76.9	2	15.4	1	7.7
6	72	91.1	3	3.8	4	5.1
7	102	95.3	1	0.9	4	3.7
8	88	88.9	4	4.0	7	7.1


9	107	96.4	2	1.8	2	1.8
10	98	92.5	5	4.7	3	2.8
Нийт	477	92.6	17	3.3	21	4.1

Сурагчдын 92.6% хоол идэхийн өмнө гараа угаах хэрэгтэй гэсэн зөв мэдлэгтэй байгаа ч эдгээр хүүхдүүдийн зөвхөн 27.9% сургууль дээрээ хоол идэхийн өмнө гараа тогтмол угааж, 25.6% огт угаахгүй байна (Зураг 6).



Зураг 6. Сургууль дээрээ хоол идэхийн өмнө гараа угаадаг, %

Сурагчдын 62.5% хоол идсэний дараа гараа угаах хэрэгтэй, 25.8% хэрэггүй, 11.7% мэдэхгүй байна. Хүйсээр харьцуулан авч үзвэл охид (63.5%) хөвгүүдээс (61.7%) хоол идсэний дараа гараа угаах хэрэгтэй гэсэн ойлголт 1.8% илүү байв (Зураг 7).



Зураг 7. Хоол идсэний дараа гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, хүйсээр, %


Хоол идсэний дараа гараа угаах хэрэгтэй эсэх талаарх мэдлэгийн түвшинг насаар харьцуулахад 6 настай сурагчдын дунд хамгийн өндөр (68.4%), 5 настай сурагчдын дунд хамгийн бага (46.2%) байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Хоол идсэний дараа гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, насаар

Нас	Хэрэгтэй		Хэрэггүй		Мэдэхгүй	
	п	%	п	%	п	%
5	6	46.2	4	30.8	3	23.1
6	54	68.4	19	24.1	6	7.6
7	72	67.3	28	26.2	7	6.5
8	60	60.6	24	24.2	15	15.2
9	63	56.8	31	27.9	17	15.3
10	67	63.2	27	25.5	12	11.3
Нийт	322	62.5	133	25.8	60	11.7

Сурагчдын дийлэнх буюу 95.5% бие зассаны дараа гараа угаах хэрэгтэй гэсэн зөв мэдлэгтэй, харин 1.2% хэрэггүй, 3.3% мэдэхгүй байна. Хүйсээр харьцуулан авч үзвэл

охид (96.4%) хөвгүүдээс (94.7%) бие зассаны дараа гараа угаах хэрэгтэй гэсэн зөв мэдлэгийн түвшин 1.7% илүү байв (Зураг 8).




Зураг 8. Бие зассаны дараа гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, хүйсээр, %

Бие зассаны дараа гараа угаах хэрэгтэй эсэх талаарх мэдлэгийн түвшинг насаар харьцуулахад 5 настай сурагчид бүгд мэддэг, харин 10 настай сурагчдын дунд зөв мэдлэгийн түвшин хамгийн бага (92.5%), нас ахих тусам зөв мэдлэгтэй сурагчдын тоо буурч байна (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Бие зассаны дараа гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, насаар

Нас	Хэрэгтэй		Хэрэггүй		Мэдэхгүй	
	п	%	п	%	п	%
5	13	100	0	0	0	0
6	77	97.5	1	1.3	1	1.3
7	104	97.2	0	0	3	2.8
8	93	93.9	1	1	5	5.1
9	107	96.4	0	0	4	3.6
10	98	92.5	4	3.8	4	3.8
Нийт	492	95.5	6	1.2	17	3.3

Сурагчдын дийлэнх буюу 99% гар бохирдсон үед гараа угаах хэрэгтэй гэсэн зөв мэдлэгтэй, харин 0.4% хэрэггүй, 0.6% мэдэхгүй байна. Хүйсээр харьцуулан авч үзвэл охид (99.6%) хөвгүүдээс (98.5%) гар бохирдсон үед гараа угаах хэрэгтэй гэсэн зөв мэдлэгийн түвшин 1.1% илүү байв (Зураг 9).




Зураг 9. Гар бохирдсон үед гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, хүйсээр, %

Гар бохирдсон үед гараа угаах хэрэгтэй эсэх талаарх зөв мэдлэгийн түвшинг насаар харьцуулахад 5 настай сурагчид бүгд мэддэг, харин 10 настай сурагчдын дунд мэдлэгийн түвшин хамгийн бага (92.5%), нас ахих тусам зөв мэдлэгтэй сурагчдын тоо буурч байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Гар бохирдсон үед гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, насаар

Нас	Хэрэгтэй		Хэрэггүй		Мэдэхгүй	
	n	%	n	%	n	%
5	13	100	0	0	0	0
6	78	98.7	0	0	1	1.3
7	105	98.1	1	0.9	1	0.9
8	98	99.0	0	0	1	1
9	111	100	0	0	0	0
10	105	99.1	1	0.9	0	0
Нийт	510	99.0	2	0.4	3	0.6

Сурагчдын дийлэнх буюу 98.8% гаднаас гэртээ орж ирсний дараа гараа угаах хэрэгтэй гэсэн зөв мэдлэгтэй байсан бол 0.4% хэрэггүй, 0.8% мэдэхгүй байна. Хүйсээр харьцуулбал охид (99.6%) хөвгүүдээс (98.1%) гар бохирдсон үед гараа угаах хэрэгтэй гэсэн зөв мэдлэгийн түвшин 1.5% илүү байв (Зураг 10).




Зураг 10. Гаднаас гэртээ орж ирсний дараа гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, хүйсээр, %

Гаднаас гэртээ орж ирсний дараа гараа угаах хэрэгтэй эсэх талаарх мэдлэгийн түвшинг насаар харьцуулахад 5, 9 настай сурагчид бүгд мэддэг, харин 7 настай сурагчдын дунд зөв мэдлэгийн түвшин хамгийн бага (97.2%), үзүүлэлттэй байна (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Гар бохирдсон үед гараа угаах хэрэгтэй эсэх талаар мэдлэг, насаар

Нас	Хэрэгтэй		Хэрэггүй		Мэдэхгүй	
	н	%	н	%	н	%
5	13	100	0	0	0	0
6	78	98.7	0	0	1	1.3
7	104	97.2	0	0	3	2.8
8	98	99.0	1	1	0	0
9	111	100	0	0	0	0
10	105	99.1	1	0.9	0	0
Нийт	509	98.8	2	0.4	4	0.8

Сурагчдын 68.9% гараа угаах дарааллын талаар мэдлэгтэй, харин 9.9% мэдлэггүй, 21.2% мэдэхгүй байна. Хүйсээр харьцуулан авч үзвэл охид (71.9%) хөвгүүдээс (66.2%) гараа угаах дарааллын талаар 5.7% илүү мэдлэгтэй байв (Зураг 11).




Зураг 11. Гараа угаах дарааллын талаарх мэдлэг, хүйсээр, %

Гараа угаах дарааллын талаарх мэдлэгийн түвшинг насаар харьцуулахад 8 настай сурагчдын дунд (78.8%) хамгийн өндөр, 10 настай сурагчдын дунд хамгийн бага (65.1%) үзүүлэлттэй байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Гараа угаах дарааллын талаарх мэдлэг, насаар

Нас	Хэрэгтэй		Хэрэггүй		Мэдэхгүй	
	н	%	н	%	н	%
5	10	76.9	1	7.7	2	15.4
6	56	70.9	6	7.6	17	21.5
7	67	62.6	14	13.1	26	24.3
8	78	78.8	6	6.1	15	15.2
9	75	67.6	12	10.8	24	21.6
10	69	65.1	12	11.3	25	23.6
Нийт	355	68.9	51	9.9	109	21.2

Таван сурагч тутмын нэг (22.5%) нь гараа 30 секундын хугацаанд, 45.4% гараа 30-60 секундын хугацаанд угаах ёстой гэсэн бол 32% мэдэхгүй байна. Хүйсээр харьцуулан авч үзвэл гараа 30 секундын хугацаанд угаах ёстой гэсэн хөвгүүд (22.9%) охидуудаас (22.1%) илүү, гараа 30-60 секундын хугацаанд угаах ёстой гэж боддог хөвгүүд (49.2%) охидуудаас (41.4%) илүү үзүүлэлттэй байв (Зураг 12).




Зураг 12. Гар угаах хугацааны талаарх мэдлэг, хүйсээр, %

Гар угаах хугацааны талаарх мэдлэгийн түвшинг насаар харьцуулахад 8 настай сурагчдын дунд 30 секунд (34.3%) хамгийн өндөр, 5 настай сурагчдын дунд 30-60 секунд (61.5%) хамгийн өндөр үзүүлэлттэй байна (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Гараа угаах хугацааны талаарх мэдлэг, насаар

Нас	30 секунд		30-60 секунд		Мэдэхгүй	
	n	%	n	%	n	%
5	2	15.4	8	61.5	3	23.1
6	14	17.7	31	39.2	34	43.0
7	29	27.1	39	36.4	39	36.4
8	34	34.3	39	39.4	26	26.3
9	24	21.6	58	52.3	29	26.1
10	13	12.3	59	55.7	34	32.1
Нийт	116	22.5	234	45.4	165	32.0

Сурагчдын дийлэнх буюу 96.1% гараа бүрэн угаахад саван шаардлагатай гэсэн зөв мэдлэгтэй бол үлдсэн 3.9% мэдлэг хангалтгүй байна (Зураг 13).




Зураг 13. Гараа бүрэн угаахад саван шаардлагатай талаарх мэдлэг, хүйсээр, %

Үнэлгээнд оролцогчдыг насаар авч үзвэл бүх насны түвшинд дийлэнх хувь гараа бүрэн угаахад саван шаардлагатай гэсэн зөв мэдлэгтэй байна (Хүснэгт 11).

Хүснэгт 11. Гараа бүрэн угаахад саван шаардлагатай талаарх мэдлэг, насаар

Нас	Гараа бүрэн угаахад саван шаардлагатай		Гараа бүрэн угаахад саван шаардлагагүй	
	п	%	п	%
5	12	92.3	1	7.7
6	74	93.7	5	6.3
7	102	95.3	5	4.7
8	96	97.0	3	3.0
9	108	97.3	3	2.7
10	103	97.2	3	2.8
Нийт	495	96.1	20	3.9

Суралцагчдын дэлхийн гар угаах өдрийн талаарх мэдлэгийг үнэлэхэд 94.8% огт мэдэхгүй, үлдсэн 5.2% тухайн өдрийг сонсож байсан ч хэдэн сард болдог талаар мэдэхгүй байна (Зураг 14).




Зураг 14. Дэлхийн гар угаах өдрийн талаарх мэдлэг, хүйсээр, %

Суралцагчдын 5.2% “Дэлхийн гар угаах өдөр”-ийн талаар сонсож байсан бөгөөд хаанаас мэдсэн талаар тодруулахад сургууль, цэцэрлэг (3.1%), эцэг эх (0.4%), найз нөхөд (0.4%), интернэт (0.4%), телевиз радио (0.2%), бусад эх үүсвэр (0.2%) гэж хариулсан байна (Хүснэгт 12).

Хүснэгт 12. Дэлхийн гар угаах өдрийн талаар мэдээллийг авсан эх сурвалж, насаар

Нас	Сургууль, цэцэрлэг		Эцэг эх		Найз нөхөд		Интернэт		Телевиз радио		Бусад	
	п	%	п	%	п	%	п	%	п	%	п	%
5	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0
6	0	0.0	1	1.3	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0
7	1	0.9	0	0.0	0	0.0	2	1.9	0	0.0	0	0.0
8	4	4.0	0	0.0	0	0.0	0	0.0	1	1.0	0	0.0
9	2	1.8	0	0.0	1	0.9	0	0.0	0	0.0	0	0.0
10	9	8.5	1	1.9	1	0.9	0	0.0	0	0.0	1	0.9
Нийт	16	3.1	2	0.4	2	0.4	2	0.4	1	0.2	1	0.2

Гар угаахын ач холбогдлын талаар суралцагчдаас тодруулахад 68.2% халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ, 18.4% гар цэвэрхэн харагдана, 1.2% ач холбогдол багатай, 12.2% мэдэхгүй гэж хариулжээ (Зураг 15).



Зураг 15. Гар угаахын ач холбогдлын талаарх мэдлэг, хүйсээр, %

Насаар ангилбал, гар угаахын ач холбогдол халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ гэдэг хариулт бүх насанд дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд нас нэмэгдэх тусам хувь нэмэгдэж байна. Харин гар цэвэрхэн харагдана, ач холбогдол багатай, мэдэхгүй гэсэн хариултууд нас нэмэгдэх тусам буурч, гар угаах талаар мэдээлэл сайтай болж байгаа нь ажиглагдаж байна (Хүснэгт 13).

Хүснэгт 13. Гар угаахын ач холбогдлын талаарх мэдлэг, насаар


Нас	Халдварт өвчнөөс сэргийлнэ		Гар цэвэрхэн харагдана		Ач холбогдол багатай		Мэдэхгүй	
	п	%	п	%	п	%	п	%
5	7	53.8	4	30.8	0	0.0	2	15.4
6	34	43.0	26	32.9	1	1.3	18	22.8
7	63	58.9	24	22.4	3	2.8	17	15.9
8	69	69.7	15	15.2	0	0.0	15	15.2
9	81	73.0	20	18.0	2	1.8	8	7.2
10	97	91.5	6	5.7	0	0.0	3	2.8
Нийт	351	68.2	95	18.4	6	1.2	63	12.2

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

- 1) Сурагчдын дийлэнх (92.6%) хоол идэхийн өмнө гар угаах хэрэгтэй гэсэн зөв мэдлэгтэй боловч сургууль дээрээ хоол идэхийн өмнө 27.9% гараа тогтмол угаадаг байв.
- 2) Гараа угаах дарааллын талаарх мэдлэгийн түвшинг насаар харьцуулахад 8 настай сурагчдын дунд (78.8%) хамгийн өндөр, 10 настай сурагчдын дунд хамгийн бага (65.1%) үзүүлэлттэй байна.
- 3) Нийт хүүхдүүдийн 96.1% гараа бүрэн угаахад саван шаардлагатай гэсэн зөв мэдлэгтэй байгаа хэдий ч эдгээр хүүхдүүдийн 57.8% сургууль дээр саван байдаггүй гэж хариулсан байв.
- 4) Үнэлгээнд хамрагдсан сурагчдын 45.4% гараа 30-60 секундын хугацаанд угаах ёстой гэсэн зөв мэдлэгтэй. Хүйсээр харьцуулан авч үзвэл хөвгүүд (49.2%) охидуудаас (41.4%) илүү, насаар авч үзвэл 5 настай сурагчдын дунд 30-60 секунд угаах ёстой гэсэн зөв мэдлэг хамгийн өндөр (61.5%) үзүүлэлттэй байна.
- 5) Суралцагчдын “Дэлхийн гар угаах өдөр”-ийг мэддэг эсэх мэдлэгийг үнэлэхэд 94.8% огт мэдэхгүй үлдсэн 5.2% тухайн өдрийн талаар сонсож байсан боловч хэдэн сард болдог талаар мэдэхгүй байна. Дэлхийн гар угаах өдрийг огт мэдэхгүй сурагчдын 69.5% сургуулиас зохион байгуулсан гарын ариун цэврийн талаарх сургалтад хамрагдаж байгаагүй, 62.3% гарын ариун цэврийн талаарх аян, олон нийтийн бусад үйл ажиллагаанд оролцдоггүй байв.
- 6) Гар угаахын ач холбогдлын талаар сурагчдын 68.2% халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ гэсэн зөв мэдлэгтэй бөгөөд нас ахих тусам гар угаах талаар мэдээлэл нэмэгдэж байгаа нь ажиглагдав.


3.3. ГАРЫН ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААРХ ХАНДЛАГА

Гарын эрүүл ахуйн хандлагын талаарх асуултыг нийтэд нь харьцуулан үзэхэд нийт үнэлгээнд хамрагдсан сурагчдын 91.5% гараа угаах нь халдварт өвчнөөс сэргийлнэ гэдэгтэй санал нийлж байна гэсэн зөв хандлагатай байсан бол 24.3% гар угаахад зөвхөн ус байхад хангалттай гэсэн байна (Зураг 16).



Зураг 16. Гарын эрүүл ахуйн талаарх хандлага

Арван сурагч тутмын 7 (72.4%) нь гар угаахад зөвхөн ус байхад хангалтгүй гэсэн зөв хандлагатай, харин 24.3% буруу хандлагатай, 3.3% мэдэхгүй байна. Хүйсээр харьцуулан авч үзвэл охид (75.1%) хөвгүүдээс (69.9%) зөв хандлагын түвшин 5.2% илүү байв (Зураг 17).




Зураг 17. Гар угаахад зөвхөн ус байхад хангалттай эсэх талаарх хандлага, хүйсээр, %

Гар угаахад зөвхөн ус байх нь хангалтгүй гэсэн зөв хандлагатай сурагчдыг насаар харьцуулахад 10 настай сурагчдын дунд хамгийн өндөр (91.5%), 5 настай сурагчдын дунд хамгийн бага (61.5%), нас ахих тусам зөв хандлагатай сурагчдын тоо өсөж байна (Хүснэгт 14).

Хүснэгт 14. Гар угаахад зөвхөн ус байхад хангалттай эсэх талаарх хандлага, насаар

Нас	Тийм		Үгүй		Мэдэхгүй	
	n	%	n	%	n	%
5	5	38.5	8	61.5	0	0
6	25	31.6	52	65.8	2	2.5
7	36	33.6	69	64.5	2	1.9
8	24	24.2	68	68.7	7	7.1
9	28	25.2	79	71.2	4	3.6
10	7	6.6	97	91.5	2	1.9
Нийт	125	24.3	373	72.4	17	3.3

Ханиалгаж, найтаасны дараа гараа угаах шаардлагатай эсэхэд үнэлгээнд хамрагдсан 10 сурагч тутмын 8 (80.2%) нь шаардлагатай гэсэн зөв хандлагатай, харин 8.9% шаардлагагүй гэсэн буруу хандлагатай, 10.9% мэдэхгүй гэсэн байна. Ханиалгаж, найтаасны дараа гараа угаах шаардлагатай гэсэн зөв хандлагатай сурагчдыг хүйсээр харьцуулахад охид (85.5%) хөвгүүдээс (75.2%) 10.3%-иар илүү байв (Зураг 18).




Зураг 18. Ханиалгаж, найтаасны дараа гараа угаах шаардлагатай эсэх талаарх хандлага, хүйсээр, %

Ханиалгаж, найтаасны дараа гараа угаах шаардлагатай гэсэн зөв хандлагатай сурагчдыг насаар харьцуулахад 7 настай сурагчдын дунд хамгийн өндөр (91%), 5 настай сурагчдын дунд хамгийн бага (61.5%), нас ахих тусам зөв хандлагатай сурагчдын тоо өсөж байна (Хүснэгт 15).

Хүснэгт 15. Ханиалгаж, найтаасны дараа гараа угаах шаардлагатай эсэх талаарх хандлага, насаар

Нас	Тийм		Үгүй		Мэдэхгүй	
	н	%	н	%	н	%
5	8	61.5	1	7.7	4	30.8
6	62	78.5	9	11.4	8	10.1
7	91	85.0	11	10.3	5	4.7
8	77	77.8	10	10.1	12	12.1
9	85	76.6	8	7.2	18	16.2
10	90	84.9	7	6.6	9	8.5
Нийт	413	80.2	46	8.9	56	10.9

Бохирдсон гараар бусдад халдвар дамжих эрсдэлтэй эсэхэд үнэлгээнд хамрагдсан 10 сурагч тутмын 8 (85%) эрсдэлтэй гэсэн зөв хандлагатай, 9.9% эрсдэлгүй буюу буруу хандлагатай, 5% мэдэхгүй байна (Зураг 19).




Зураг 19. Бохирдсон гараар бусдад халдвар дамжих эрсдэлтэй эсэх талаарх хандлага, хүйсээр, %

Бохирдсон гараар бусдад халдвар дамжих эрсдэлтэй гэсэн зөв хандлагатай сурагчдыг насаар харьцуулахад 9 настай сурагчдын зөв хандлагын түвшин хамгийн өндөр (93.7%), харин 5 настай сурагчдын дунд хамгийн бага (61.5%), нас ахих тусам зөв хандлагатай сурагчдын тоо өсөж байна (Хүснэгт 16).

Хүснэгт 16. Бохирдсон гараар бусдад халдвар дамжих эрсдэлтэй эсэх талаарх хандлага, насаар

Нас	Тийм		Үгүй		Мэдэхгүй	
	н	%	н	%	н	%
5	8	61.5	4	7.8	1	3.8
6	60	75.9	12	23.5	7	26.9
7	84	78.5	16	31.4	7	26.9
8	84	84.8	11	21.6	4	15.4
9	104	93.7	4	7.8	3	11.5
10	98	92.5	3	5.9	4	15.4
Нийт	438	85.0	51	9.9	26	5.0

Гараа усаар сайтар угаасан бол саван хэрэглэх шаардлагатай эсэхэд үнэлгээнд хамрагдсан 10 сурагч тутмын 7 (75.9%) нь шаардлагатай гэж бодсон зөв хандлагатай, харин 18.4% шаардлагагүй буюу буруу хандлагатай, 5.6% мэдэхгүй байна. Гараа усаар сайтар угаасан бол саван хэрэглэх шаардлагатай гэсэн зөв хандлагатай сурагчдыг хүйсээр харьцуулахад охидууд (77.1%) хөвгүүдээс (74.8%) 2.3%-иар илүү байв (Зураг 20).




Зураг 20. Хэрэв гараа усаар сайтар угаасан бол саван хэрэглэх шаардлагатай эсэх талаарх хандлага, хүйсээр, %

Гараа усаар сайтар угаасан ч саван хэрэглэх шаардлагатай гэсэн зөв хандлагатай сурагчдыг насаар харьцуулахад 5 настай сурагчдын зөв хандлагын түвшин хамгийн өндөр (84.6%), харин 7 настай сурагчдын 27.1% шаардлагагүй гэж боддог буюу буруу хандлагын хамгийн өндөр хувийг эзэлж байна (Хүснэгт 17).

Хүснэгт 17. Хэрэв гараа усаар сайтар угаасан бол саван хэрэглэх шаардлагатай эсэх талаарх хандлага, насаар

Нас	Тийм		Үгүй		Мэдэхгүй	
	н	%	н	%	н	%
5	11	84.6	1	7.7	1	7.7
6	64	81.0	12	15.2	3	3.8
7	75	70.1	29	27.1	3	2.8
8	80	80.8	14	14.1	5	5.1
9	77	69.4	24	21.6	10	9.0
10	84	79.2	15	14.2	7	6.6
Нийт	391	75.9	95	18.4	29	5.6

Гараа угаах нь халдварт өвчнөөс сэргийлнэ гэдэгтэй санал нийлж байгаа эсэхэд үнэлгээнд хамрагдсан 10 сурагч тутмын 9 (91.5%) нь санал нийлж байна гэсэн зөв хандлагатай, 4.1% санал нийлэхгүй, 4.5% мэдэхгүй байна. Гараа угаах нь халдварт өвчнөөс сэргийлнэ гэсэн зөв хандлагатай сурагчдыг хүйсээр харьцуулахад охидууд (92.4%) хөвгүүдээс (90.6%) 1.8%-иар илүү байв (Зураг 21).



Зураг 21. Гараа угаах нь халдварт өвчнөөс сэргийлнэ гэдэгтэй санал нийлж байгаа эсэх талаарх хандлага, хүйсээр, %

Гараа угаах нь халдварт өвчнөөс сэргийлнэ гэсэн зөв хандлагатай сурагчдыг насаар харьцуулахад 9 настай сурагчдын зөв хандлагын түвшин хамгийн өндөр (94.6%), харин 5 настай сурагчдын дунд хамгийн бага (84.6%), нас ахих тусам зөв хандлагатай сурагчдын тоо өсч байна (Хүснэгт 18).

Хүснэгт 18. Гараа угаах нь халдварт өвчнөөс сэргийлнэ гэдэгтэй санал нийлж байгаа эсэх талаарх хандлага, насаар

Нас	Тийм		Үгүй		Мэдэхгүй	
	n	%	n	%	n	%
5	11	84.6	2	15.4	0	0
6	68	86.1	5	6.3	6	7.6
7	95	88.8	8	7.5	4	3.7
8	92	92.9	2	2.0	5	5.1
9	105	94.6	1	0.9	5	4.5
10	100	94.3	3	2.8	3	2.8
Нийт	471	100	21	100	23	4.5


БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

- 1) Үнэлгээнд оролцсон 3 сурагч тутмын хоёр (72.4%) нь гар угаахад зөвхөн ус байх хангалтгүй гэж боддог зөв хандлагатай байна.
- 2) Сурагчдын дийлэнх (80.2%) нь ханиалгаж, найтаасны дараа гараа угаах шаардлагатай гэж боддог зөв хандлагатай байв.
- 3) Бохирдсон гараар бусдад халдвар дамжих эрсдэлтэй гэсэн зөв хандлагатай сурагчид хамгийн өндөр буюу 85%-ийг эзэлж, харин 75.9% гараа усаар сайтар угаасан ч саван хэрэглэх шаардлагатай гэсэн зөв хандлагатай байна.
- 4) Үнэлгээнд хамрагдсан сурагчдын дийлэнх (91.5%) гараа угаах нь халдварт өвчнөөс сэргийлнэ гэсэн зөв хандлагатай байв.
- 5) Сурагчдын дийлэнх хувь нь зөв хандлагатай ба хүйсээр харьцуулахад охидууд хөвгүүдээс илүү, нас ахих тусам зөв хандлагатай сурагчид нэмэгдэж байгаа нь ажиглагдав. Харин бохирдсон гараар бусдад халдвар дамжих эрсдэлтэй гэсэн зөв хандлагатай сурагчид өдөрт дунджаар 3-4 удаа гараа угаадаг байна.

3.4. ГАРЫН ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААРХ ДАДАЛ

Сурагчдын өдөрт дунджаар гараа угаах дундаж үзүүлэлт 3.75 (95%ИХ 3.56-3.98) удаа байна. Хүйсээр харьцуулахад хөвгүүд өдөрт дунджаар 3.72 (95%ИХ 3.44-4.04), охидууд өдөрт дунджаар 3.79 (95%ИХ 3.52-4.03) удаа гараа угаадаг байв.

Гарын эрүүл ахуйн талаарх дадлын асуултуудыг нийтэд нь харьцуулан үзэхэд үнэлгээнд хамрагдсан сурагчдын 90.9% өглөө гараа угаадаг зөв дадалтай байгаа ба 58.3% сургууль дээрээ гараа угаадаг байна (Зураг 22).



Зураг 22. Гарын эрүүл ахуйн талаарх дадлын асуултуудыг харьцуулан үзэхэд

Гараа угаахдаа саван хэрэглэдэг эсэх асуултад үнэлгээнд оролцогчдын дийлэнх буюу 97.5% гараа угаахдаа саван хэрэглэдэг зөв дадалтай, 1.6% хэрэглэдэггүй, 1% мэдэхгүй байна. Насаар авч үзэхэд 5-6 настай хүүхдүүд хамгийн өндөр буюу 100% тийм гэж хариулсан байна. Харин 9 настай хүүхдүүд хамгийн өндөр буюу гараа угаахдаа саван хэрэглэдэггүй гэж (3.6%) хариулжээ (Хүснэгт 19).

Хүснэгт 19. Гараа угаахдаа саван хэрэглэдэг эсэх дадал, насаар

Нас	Тийм		Үгүй		Мэдэхгүй	
	п	%	п	%	п	%
5	13	100	0	0	0	0
6	79	100	0	0	0	0
7	104	97.2	1	0.9	2	1.9
8	97	98	1	1	1	1
9	106	95.5	4	3.6	1	0.9
10	103	97.2	2	1.9	1	0.9
Нийт	502	97.5	8	1.6	5	1

Хүйсээр харьцуулан авч үзвэл эрэгтэй 96% тийм, эмэгтэй 99% тийм, үгүй гэж хариулсан эрэгтэй 2%, эмэгтэй 1% байна (Зураг 23).




Зураг 23. Гараа угаахдаа саван хэрэглэдэг эсэх дадал, хүйсээр

Өглөө гараа угаадаг эсэх асуултад үнэлгээнд оролцогчдын 90.9% тийм гэж хариулсан бол 9.1% үгүй, үлдсэн 1% мэдэхгүй байна. Насаар авч үзэхэд 7 настай хүүхдүүд хамгийн өндөр буюу 96.3% тийм гэж хариулсан байна. Харин 5 настай хүүхдүүд өглөө гараа угаадаггүй гэж хамгийн өндөр буюу 15.4% хариулжээ (Хүснэгт 20).

Хүснэгт 20. Өглөө гараа угаах дадал, насаар

Нас	Тийм		Үгүй	
	n	%	n	%
5	11	84.6	2	15.4
6	69	87.3	10	12.7
7	103	96.3	4	3.7
8	95	96	4	4
9	97	87.4	14	12.6
10	93	87.7	13	12.3
Нийт	468	90.9	47	9.1

Өглөө гараа угаадаг эсэх асуултад хүйсээр харьцуулан авч үзвэл эрэгтэй 88% тийм, эмэгтэй 94% тийм, харин өглөө гараа угаадаггүй гэж хариулсан эрэгтэй 12%, эмэгтэй 6% байна. Үүнээс үзэхэд үнэлгээнд оролцогчдын 90.9% зөв дадалтай байна (Зураг 24).




Зураг 24. Өглөө гараа угаадаг эсэх дадал, хүйсээр

Гараа хэрхэн угаадаг эсэх асуултад үнэлгээнд оролцогчдын 86.6% савандаж, усаар угаадаг гэж хариулсан бол 9.1% өглөө гараа угаадаггүй, үлдсэн 4.3% зөвхөн усаар угаадаг байна. Насаар авч үзэхэд 8 настай хүүхдүүд хамгийн өндөр буюу 92.9% савандаж, усаар угаадаг гэж хариулсан байна. Харин 5 настай хүүхдүүд өглөө гараа угаадаггүй гэж 15.4% хариулжээ (Хүснэгт 21).

Хүснэгт 21. Гараа хэрхэн угаадаг талаарх дадал, насаар

Нас	Өглөө гараа угаадаггүй		Савандаж, усаар угаасан		Зөвхөн усаар угаасан	
	n	%	n	%	n	%
5	2	15.4	11	84.6	0	0
6	10	12.7	65	52.3	4	5.1
7	4	3.7	98	91.6	5	4.7
8	4	4	92	92.9	3	3
9	14	12.6	92	82.9	5	4.5
10	13	12.3	88	83	5	4.7
Нийт	47	9.1	446	86.6	22	4.3

Гараа хэрхэн угаадаг эсэх асуултыг хүйсээр харьцуулан авч үзвэл эрэгтэй 83.8% савандаж, усаар угаадаг, эмэгтэй 89.6% савандаж, усаар угаадаг, харин өглөө гараа угаадаггүй гэж хариулсан эрэгтэй 12%, эмэгтэй 6% байна (Зураг 25).




Зураг 25. Гараа хэрхэн угаадаг талаарх дадал, хүйсээр

Гараа угаахдаа зарцуулдаг хугацааны талаарх асуултад үнэлгээнд оролцогчдын 42.7% 30 секундээс 1 мин хүртэл гэж хариулсан бол 30.5% 30 секунд хүртэл, үлдсэн 26.8% мэдэхгүй гэж хариулсан байна. Насаар авч үзэхэд 10 настай хүүхдүүд хамгийн өндөр буюу 51,9% 30 секундээс 1 мин хүртэл гэж хариулсан байна. Харин 6 настай хүүхдүүдийн 43% мэдэхгүй хариулжээ (Хүснэгт 22).

Хүснэгт 22. Гараа угаахдаа зарцуулдаг хугацаа, насаар

Нас	30 секунд хүртэл		30 секунд- 1 мин хүртэл		Мэдэхгүй	
	н	%	н	%	н	%
5	6	46.2	5	38.5	2	15.4
6	18	22.8	27	34.2	34	43
7	28	26.2	45	42.1	34	31.8
8	42	42.2	34	34.3	23	23.2
9	31	27.9	54	48.6	26	23.4
10	32	30.2	55	51.9	19	17.9
Нийт	157	30.5	220	42.7	138	26.8

Гараа угаахдаа зарцуулсан минутыг хүйсээр харьцуулан авч үзвэл эрэгтэй 45.1% 30 секундээс 1 мин хүртэл, эмэгтэй 40.2% 30 секундээс 1 мин хүртэл, харин 30 секунд хүртэл гэж хариулсан эрэгтэй 33.1%, эмэгтэй 27.7% байна (Зураг 26).




Зураг 26. Гараа угаахдаа зарцуулсан хугацаа, хүйсээр

Сургууль дээрээ гараа угаадаг эсэх асуултад үнэлгээнд оролцогчдын 58.3% тийм гэж хариулсан бол 21.6% үгүй, үлдсэн 20.2% заримдаа гэж хариулсан байна. Насаар авч үзэхэд 7 настай хүүхдүүд хамгийн өндөр буюу 75.7% сургууль дээрээ гараа угаадаг гэж хариулсан байна. Харин 10 настай хүүхдүүдийн 27.4% сургууль дээрээ гараа угаадаггүй гэж хариулжээ (Хүснэгт 23).

Хүснэгт 23. Сургууль дээрээ гараа угаах дадал, насаар

Нас	Тийм		Үгүй		Заримдаа	
	п	%	п	%	п	%
5	8	61.1	2	15.4	3	23.1
6	52	65.8	19	24.1	8	10.1
7	81	75.7	16	15	10	9.3
8	55	55.6	18	18.2	26	26.3
9	57	51.4	27	24.3	27	24.3
10	47	44.3	29	27.4	30	28.3
Нийт	300	58.3	111	21.6	104	20.2

Сургууль дээрээ гараа угаадаг эсэх асуултад үнэлгээнд оролцогчдыг хүйсээр харьцуулан авч үзвэл эрэгтэй 51.9% тийм, эмэгтэй 65.1% тийм, харин үгүй гэж хариулсан эрэгтэй 28.6%, эмэгтэй 14.1% байна (Зураг 27).




Зураг 27. Сургууль дээрээ гараа угаах дадал, хүйсээр

Сургууль дээр байхдаа гараа хэрхэн угааж цэвэрлэдэг эсэх асуултад үнэлгээнд оролцогчдын 42.1% савандаж, усаар угаадаг гэж хариулсан бол 37.1% зөвхөн усаар угаасан, 11.1% огт угаадаггүй гэж хариулсан байна. Насаар авч үзэхэд 8 настай хүүхдүүд хамгийн өндөр буюу 53.9% сургууль дээрээ савандаж, усаар угаадаг гэж хариулсан байна. Харин 10 настай хүүхдүүдийн 11.1% сургууль дээрээ гараа угаадаггүй гэж хариулжээ (Хүснэгт 24).

Хүснэгт 24. Сургууль дээр байхдаа гараа хэрхэн угааж цэвэрлэдэг эсэх, шалтгаан, насаар

Нас	Савандаж, усаар угаасан		Зөвхөн усаар угаасан		Гар халдваргүйжүүлэгч уусмалаар арчдаг		Нойтон салфетикаар арчдаг		Угаадаггүй	
	n	%	n	%	n	%	n	%	n	%
5	6	46.2	4	30.8	0	0	2	15.4	1	7.7
6	24	30.4	29	36.7	4	5.1	7	8.9	15	19
7	47	43.9	45	42.1	0	0	6	5.6	9	8.4
8	53	53.9	34	34.3	2	2	4	4	6	6.1
9	46	41.4	42	37.8	5	4.5	6	5.4	12	10.8
10	41	38.7	37	34.9	6	5.7	8	7.5	14	13.2
Нийт	217	42.1	191	37.1	17	3.3	33	6.4	57	11.1

Сургууль дээр байхдаа гараа хэрхэн угааж цэвэрлэдэг эсэх асуултад үнэлгээнд оролцогчдыг хүйсээр харьцуулан авч үзвэл эрэгтэй 39.5% савандаж, усаар угаадаг, эмэгтэй 45% савандаж, усаар угаадаг, харин огт угаадаггүй гэж хариулсан эрэгтэй 14.7%, эмэгтэй 14.1% байна (Зураг 28).




Зураг 28. Сургууль дээр байхдаа гараа хэрхэн угааж цэвэрлэдэг эсэх, шалтгаан, хүйсээр

Сургуулийн ариун цэврийн өрөөнд саван байдаг эсэх асуултад үнэлгээнд оролцогчдын 57.9% үгүй гэж хариулсан бол 27.4% тийм, 14.8% заримдаа гэж хариулсан байна. Насаар авч үзэхэд 5 настай хүүхдүүд хамгийн өндөр буюу 38.5% сургуулийн ариун цэврийн өрөөнд саван байдаг гэж хариулжээ. Харин 6 настай хүүхдүүдийн 72.2% сургуулийн ариун цэврийн өрөөнд саван байдаггүй гэж хариулжээ (Хүснэгт 25).

Хүснэгт 25. Сургуулийн ариун цэврийн өрөөнд саван байдаг эсэх, насаар


Нас	Тийм		Үгүй		Заримдаа	
	n	%	n	%	n	%
5	5	38.5	7	53.8	1	7.7
6	16	20.3	57	72.2	6	7.6
7	31	29	69	64.5	7	6.5
8	32	32.3	48	48.5	19	19.2
9	33	29.7	55	49.5	23	20.7
10	24	22.6	62	58.5	20	18.9
Нийт	141	27.4	298	57.9	76	14.8

Нийт хүүхдүүдийн 96.1% гараа бүрэн угаахад саван шаардлагатай гэсэн зөв мэдлэгтэй ч эдгээр хүүхдүүдийн 57.8% сургууль дээр саван байдаггүй гэж хариулсан байна (Зураг 29).



Зураг 29. Сургуулийн ариун цэврийн өрөөнд саван байдаг эсэх, %

Сургуулийн ариун цэврийн өрөөнд саван байдаг эсэх асуултад үнэлгээнд оролцогчдыг хүйсээр харьцуулан авч үзвэл эрэгтэй 57.1% сургуулийн ариун цэврийн өрөөнд саван байдаггүй, эмэгтэй 58.6% сургуулийн ариун цэврийн өрөөнд саван байдаггүй, харин заримдаа сургуулийн ариун цэврийн өрөөнд саван байдаг гэж эрэгтэй 30.1%, эмэгтэй 24.5% хариулсан байна (Зураг 30).




Зураг 30. Сургуулийн ариун цэврийн өрөөнд саван байдаг эсэх, хүйсээр

Сургууль дээрээ хоол идэхийн өмнө гараа угаадаг эсэх асуултад үнэлгээнд оролцогчдын 33.6% заримдаа гэж хариулсан бол 27.4% тогтмол, 25.8% хэзээ ч угаадаггүй гэж хариулсан байна. Насаар авч үзэхэд 6 настай хүүхдүүд хамгийн өндөр буюу 34.2% сургууль дээрээ хоол идэхийн өмнө гараа угаадаг гэж хариулжээ. Харин 10 настай хүүхдүүдийн 32.1% сургууль дээрээ хоол идэхийн өмнө хэзээ ч гараа угаадаггүй гэж хариулжээ (Хүснэгт 26).

Хүснэгт 26. Сургууль дээрээ хоол идэхийн өмнө гараа угаах дадал, насаар


Нас	Тогтмол		Ихэнх үед		Заримдаа		Хэзээ ч угаадаггүй	
	n	%	n	%	n	%	n	%
5	4	30.8	2	15.4	4	30.8	3	23.1
6	27	34.2	13	16.5	17	21.5	22	27.8
7	36	33.6	16	15	36	33.6	19	17.8
8	28	28.3	13	13.1	36	36.4	22	22.2
9	30	27	11	9.9	37	33.3	33	29.7
10	16	15.1	13	12.3	43	40.6	34	32.1
Нийт	141	27.4	68	13.2	173	33.6	133	25.8

Сургууль дээрээ хоол идэхийн өмнө гараа угаадаг эсэх асуултад үнэлгээнд оролцогчдыг хүйсээр харьцуулан авч үзвэл эрэгтэй 22.2% сургууль дээрээ хоол идэхийн өмнө гараа угаадаг, эмэгтэй 32.9% сургууль дээрээ хоол идэхийн өмнө гараа угаадаг, харин заримдаа сургууль дээрээ хоол идэхийн өмнө гараа угаадаг гэж эрэгтэй 35%, эмэгтэй 32.1% хариулсан байна. Хэзээ ч угаадаггүй гэж эрэгтэй 32.3%, эмэгтэй 18.9% хариулжээ (Зураг 31).




Зураг 31. Сургууль дээрээ хоол идэхийн өмнө гараа угаах дадал, хүйсээр

Сургууль дээрээ ямар тохиолдолд гараа угаадаг эсэх шалтгаанаар авч үзэхэд үнэлгээнд оролцогчдын 58.4% бие зассаны дараа, 35.3% гар бохирдсон үед, 28.1% сургууль дээр юм идэхийн өмнө, 11.5% угаадаггүй гэж хариулсан байна (Зураг 32).




Зураг 32. Сургууль дээрээ гараа угаах дадал, шалтгаанаар, %

Гараа угаадаггүй бол шалтгаанаар нь авч үзэхэд үнэлгээнд оролцогчдын 11.1% саван байдаггүй, 6% угаалтуур байдаггүй / эвдэрхий, ажилладаггүй/, 4.3% гар угаах цаг гардаггүй, 6.6% бусад гэж хариулсан байна (Зураг 33).



Зураг 33. Гараа угаадаггүй бол шалтгаан, %

Дэлхийн гар угаах өдрийг огт мэдэхгүй сурагчдын 69.5% сургуулиас зохион байгуулсан гарын ариун цэврийн талаарх сургалтад хамрагдаж байгаагүй, 62.3% гарын ариун цэврийн талаарх аян болон олон нийтийн үйл ажиллагаанд оролцож байгаагүй байна (Зураг 34).




Зураг 34. Сургалт, олон нийтийн үйл ажиллагаанд оролцож байсан эсэх, %

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

- 1) Гараа угаахдаа саван хэрэглэдэг дадал сурагчдын 97.5% тийм гэж хариулсан байна. Насаар авч үзэхэд 5-6 насанд хамгийн өндөр буюу 99.8%-тай байв.
- 2) Үнэлгээнд оролцогчдын 90.9% өглөө тогтмол гараа угаадаг ба гараа 86.6% савандаж угаадаг зөв дадалтай байна.
- 3) Гараа угаахдаа 42.7% 30 секундээс 1 минутын хугацаанд гараа угаадаг бол 30.5% 30 секунд хүртэл, үлдсэн 26.8% гараа угаахдаа ямар хугацаа зарцуулдгаа мэддэггүй байв.
- 4) Сургууль дээрээ 2 хүүхэд тутмын нэг (58.3%) нь гараа угаадаг, харин сургууль дээрээ гараа угаахдаа 42.1% савандаж, усаар угаадаг, 37.1% зөвхөн усаар угаадаг, 11.1% огт угаадаггүй байв.
- 5) Сурагчдын 33.6% заримдаа л сургууль дээрээ хоол идэхийн өмнө гараа угаадаг, 27.4% тогтмол, 25.8% хэзээ ч угаадаггүй байна.
- 6) Сурагчдын 2 хүүхэд тутмын нэг (57.9%) нь сургуулийн ариун цэврийн өрөөнд саван байдаггүй гэж хариулсан байв.
- 7) Сурагчдын өдөрт гараа угаах дундаж 3.75 (95%ИХ 3.56-3.98) удаа байна. Гэр хороололд амьдардаг сурагчдын 55.7%, орон сууцанд амьдардаг сурагчдын 59.7% тогтмол гараа угаадаг байна. Гар угаах дадал нь амьдардаг орчинтой хамааралгүй байна.

3.5. ГАРЫН ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

Сургуулиас зохион байгуулсан гарын ариун цэврийн талаарх сургалтад хамрагдаж байсан талаар тодруулахад үнэлгээнд оролцогчдын 31.5% сургалтад хамрагдаж байсан байна. Хамрагдаж байсан нийт хүүхдүүдээс эрэгтэй 32.7%, эмэгтэй 30.1% байна. Үлдсэн 68.5% ямар нэг сургалтад хамрагдаж байгаагүй байна. Үүнээс 67.3% эрэгтэй, 69.9% эмэгтэй байна (Зураг 35).




Зураг 35. Сургуулиас зохион байгуулсан гарын ариун цэврийн талаарх сургалтад хамрагдаж байсан байдал, хүйсээр, %

Сургуулиас зохион байгуулсан гарын ариун цэврийн талаарх сургалтад хамрагдаж байсан сурагчдыг насаар харьцуулж үзэхэд 5 настай сурагчдын 23.1%, 6 настай сурагчдын 44.3% , 7 настай сурагчдын 28%, 8 настай сурагчдын 42.4%, 9 настай сурагчдын 21.6%, 10 настай сурагчдын 26.4% байна. Үүнээс 6 настай сурагчдын 44.3% буюу хамгийн их хувь нь сургалтад хамрагдаж байсан байна. Харин сургуулиас зохион байгуулсан гарын ариун цэврийн талаарх сургалтад 9 настай сурагчдын 78.4% буюу хамгийн их хувь нь хамрагдаж байгаагүй байна (Хүснэгт 27).

Хүснэгт 27. Сургуулиас зохион байгуулсан гарын ариун цэврийн талаарх сургалтад хамрагдаж байсан эсэх, насаар

Нас	Хамрагдаж байсан		Хамрагдаж байгаагүй	
	n	%	n	%
5	3	23.1	10	76.9
6	35	44.3	44	55.7
7	30	28	77	72
8	42	42.4	57	57.6
9	24	21.6	87	78.4
10	28	26.4	78	73.6
Нийт	162	31.5	353	68.5

Сургуулийн орчинд гарын эрүүл ахуй сахих талаар сурталчилгааны материал байдаг эсэхийг тодруулахад нийт сурагчдын 37.1%, хүйсээр харьцуулж үзэхэд эрэгтэй сурагчдын 39.1%, эмэгтэй сурагчдын 34.9% байдаг гэж хариулсан байна. Сурагчдын 40.8% сургуулийн орчинд сурталчилгааны материал байдаггүй гэж хариулсан бол үлдсэн 22.1% мэдэхгүй байна (Зураг 36).




Зураг 36. Сургуулийн орчинд сургалт сурталчилгааны материал байдаг талаар хариулсан байдал, хүйсээр, %

Сургуулийн орчинд сургалт сурталчилгааны материал байдаг эсэхийг тодруулж, насны ангиллаар харьцуулж үзэхэд 5 настай сурагчдын 46.2% байдаг гэж хариулсан байна. Энэ нь бусад насны сурагчидтай харьцуулахад өндөр байна. 6 настай сурагчдын 49.4% сургуулийн орчинд гар угаах сурталчилгааны материал байдаггүй гэсэн байна (Хүснэгт 28).

Хүснэгт 28. Сургуулийн орчинд сургалт сурталчилгааны материал байдаг талаар хариулсан байдал, насаар

Нас	Гар угаах МССМ байдаг (сургуулийн орчинд)		Гар угаах МССМ байдаггүй (сургуулийн орчинд)		Мэдэхгүй	
	n	%	n	%	n	%
5	6	46.2	1	7.7	6	46.2
6	22	27.8	39	49.4	18	22.8
7	49	45.8	47	43.9	11	10.3
8	34	34.3	45	45.5	20	20.2
9	39	35.1	45	40.5	27	24.3
10	41	38.7	33	31.1	32	30.2
Нийт	191	37	210	40.7	114	22.1

Үнэлгээнд хамрагдсан нийт сурагчдаас ангид гарын эрүүл ахуй сахих талаар сурталчилгааны материал байдаг эсэхийг тодруулахад 43.5% байдаггүй гэсэн байна. Харин 37.9% байдаг гэж хариулсан бол үлдсэн 18.6% мэдэхгүй байна. Хүйсийн хувьд харьцуулж үзэхэд эмэгтэй сурагчдын 43%, эрэгтэй сурагчдын 44% ангид сургалт сурталчилгааны материал байдаггүй гэсэн нь ойролцоо түвшинд байна (Зураг 37).



Зураг 37. Ангид сургалт сурталчилгааны материал байдаг талаар хариулсан байдал, хүйсээр, %


Үнэлгээнд хамрагдсан 8 настай сурагчдын 49.5%, 6 настай сурагчдын 24.1% ангид гарах угаах сурталчилгааны материал байдаг гэж хариулсан байна. 5 настай сурагчдын 30.8% мэдэхгүй байна (Хүснэгт 29).

Хүснэгт 29. Ангид сургалт сурталчилгааны материал байдаг эсэх, насаар

Нас	Гар угаах МССМ байдаг (ангид)		Гар угаах МССМ байдаггүй (ангид)		Мэдэхгүй	
	п	%	п	%	п	%
5	4	30.8	5	38.1	4	30.8
6	19	24.1	48	60.8	12	15.2
7	46	43	48	44.9	13	12.1
8	49	49.5	31	31.3	19	19.2
9	33	29.7	52	46.8	26	23.4
10	44	41.5	40	37.7	22	20.8
Нийт	195	37.8	224	43.4	96	18.6

Нийт сурагчдаас гарын ариун цэврийн талаарх аян болон олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байсан эсэхийг тодруулахад 61% буюу дийлэнх нь оролцож

байгаагүй байв. Сурагчдын 17.5% оролцож байсан бол үлдсэн 21.6% мэдэхгүй гэж хариулсан байна. Эрэгтэй сурагчид 18%, эмэгтэй сурагчид 16.9% байгаа нь олон нийтийн үйл ажиллагаанд оролцох түвшин хүйсийн хувьд ойролцоо байна (Зураг 38).



Зураг 38. Гарын ариун цэврийн талаарх аян болон олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байсан эсэх, хүйсээр


Үнэлгээнд хамрагдсан нийт 6 настай сурагчдын 15.2% олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байсан бол 78.5% олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байгаагүй байна. 9 настай сурагчдын 36.9% мэдэхгүй гэж хариулт өгсөн байна (Хүснэгт 30).

Хүснэгт 30. Гарын ариун цэврийн талаарх аян болон олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байсан эсэх, насаар

Нас	Оролцож байсан		Оролцож байгаагүй		Мэдэхгүй	
	н	%	н	%	н	%
5	3	23.1	8	61.5	2	15.4
6	12	15.2	62	78.5	5	6.3
7	15	14	78	72.9	14	13.1
8	23	23.2	49	49.5	27	27.3
9	17	15.3	53	47.7	41	36.9
10	20	18.9	64	60.4	22	20.8
Нийт	90	17.4	314	60.9	111	21.5

Гарын ариун цэвэр сахих талаарх мэдээ мэдээллийг сурагчид ихэнх тохиолдолд эрүүл мэндийн байгууллага болон найз нөхөд, гэр бүлээсээ авдаг байна. Энэ нь өдөр тутамд хийдэг дадлуудын нэг тул ойрын хүрээллээсээ мэдээлэл авдаг байна. Сурагчдын гарын ариун цэврийг сахих талаарх мэдээ, мэдээллийг хаанаас олж авч байгааг

хүйсээр харьцуулан үзвэл эмэгтэй сурагчдын 30.1% эрүүл мэндийн байгууллага, эрэгтэй сурагчдын 7.5% сургалт, тв, интернэт зэргээс буюу эрэгтэй эмэгтэй сурагчдын мэдээлэл авах түвшин ойролцоо байна. Харин гэр бүл найз нөхдөөс мэдээлэл авах эмэгтэй сурагчдад илүү байна (Зураг 39).




Зураг 39. Гарын ариун цэвэр сахих талаарх мэдээллийг хаанаас олж авдаг эсэх, %

Гарын ариун цэвэр сахих талаарх мэдээ, мэдээллийг хаанаас олж авдаг талаар тодруулахад 5-10 настай сурагчдын дийлэнх хувь гэр бүл, найз нөхдөөсөө авдаг гэж хариулсан байна (Хүснэгт 31).

Хүснэгт 31. Гарын ариун цэвэр сахих талаарх мэдээллийг хаанаас олж авдаг эсэх насаар, %

Нас	Эрүүл мэндийн байгууллагаас	Сургалтаас	Сурталчилгааны материал	ТВ, Радио	Интернет, фэйсбүүк	Гэр бүл, найз нөхөд	Бусад	Мэдээлэл олж авч чаддаггүй
5	30.8	7.7	7.7	15.4	7.7	30.8	0	0
6	12.7	3.8	2.5	11.4	7.6	50.6	7.6	3.8
7	16.8	11.2	4.7	11.2	5.6	43.9	3.7	2.8
8	36.4	5.1	5.1	7.1	5.1	33.3	3	5.1
9	40.5	5.4	3.6	6.3	6.3	27.9	4.5	5.4
10	32.1	8.5	6.6	10.4	12.3	22.6	6.6	0.9

Гарын ариун цэвэр сахих талаар мэдээ, мэдээллийг ямар хэлбэрээр авбал сонирхолтой талаар сурагчдаас тодруулахад 42.7% эмч, 14.8% сургалт, интернэт, видео анимейшн зэргээс авах сонирхолтой гэж хариулсан байна. Сурагчид мэргэжлийн эмч нарын зөвлөгөө мэдээлэлд илүү анхаарал хандуулж, зөвлөгөөг өдөр тутамдаа дадал болгох хандлага ажиглагдаж байна (Зураг 40).




Зураг 40. Гарын ариун цэвэр сахих талаарх мэдээ, мэдээллийг ямар хэлбэрээр авбал сонирхолтой талаар, %

Гарын ариун цэвэр сахих талаарх мэдээллийг ямар хэлбэрээр авбал сонирхолтой талаар тодруулахад 5 настай сурагчдын 30.3%, 6 настай сурагчдын 34.2%, 7 настай сурагчдын 31.4%, 8 настай сурагчдын 53.5%, 9 настай сурагчдын 48.6%, 10 настай сурагчдын 45.3% эмчээс авах гэж хариулсан байна (Хүснэгт 32).

Хүснэгт 32. Гарын ариун цэвэр сахих талаар мэдээллийг ямар хэлбэрээр авбал сонирхолтой талаар насаар n, %

Нас	Эмчээс		Сургалт		МСС		Видео		ЭМ-ын олон нийтийн үйл ажиллагаа		ТВ, Радио		Интернэт	
	n	%	n	%	n	%	n	%	n	%	n	%	n	%
5 нас	4	30.8	1	7.7	1	7.7	1	7.7	1	7.7	1	7.7	4	30.8
6 нас	27	34.2	7	8.9	6	7.6	15	19	0	0	13	16.5	11	13.9
7 нас	34	31.8	18	16.8	6	5.6	15	14	6	5.6	14	13.1	14	13.1
8 нас	53	53.5	15	15.2	3	3	6	6.1	4	4.1	4	4.1	14	14.1
9 нас	54	48.6	15	13.5	12	10.8	12	10.8	5	4.5	3	2.7	3	2.8
10 нас	48	45.3	20	18.9	8	7.5	14	13.2	3	2.8	3	2.8	10	9.4

Нийт сурагчдаас гарын ариун цэврийн талаарх аян болон олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байсан эсэхийг тодруулахад 61% буюу дийлэнх нь оролцож байгаагүй байв. Сурагчдын 17.5% оролцож байсан бол үлдсэн 21.6% мэдэхгүй гэж хариулсан байна. Эрэгтэй сурагчид 18%, эмэгтэй сурагчид 16.9% байгаа нь олон нийтийн үйл ажиллагаанд оролцох түвшин хүйсийн хувьд ойролцоо байна (Зураг 41).




Зураг 41. Гарын ариун цэврийн талаарх аян болон олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байсан эсэх, хүйсээр, %

Үнэлгээнд хамрагдсан нийт 6 настай сурагчдын 15.2% олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байсан бол 78.5% олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байгаагүй байна. 9 настай сурагчдын 36.9% мэдэхгүй гэж хариулт өгсөн байна (Хүснэгт 33).

Хүснэгт 33. Гарын ариун цэврийн талаарх аян болон олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байсан эсэх, насаар n, %

Нас	Олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байсан		Олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байгаагүй		Мэдэхгүй	
	n	%	n	%	n	%
5	3	23.1	8	61.5	2	15.4
6	12	15.2	62	78.5	5	6.3
7	15	14	78	72.9	14	13.1
8	23	23.2	49	49.5	27	27.3
9	17	15.3	53	47.7	41	36.9
10	20	18.9	64	60.4	22	20.8
Нийт	90	17.4	314	60.9	111	21.5

Үнэлгээнд хамрагдсан нийт сурагчдаас гар угаах дарааллыг мэддэг сурагчдын 36.3% сургуулиас зохион байгуулсан гарын ариун цэврийн талаарх сургалтад хамрагдаж байсан байна. Сурагчдын 21.4% гарын ариун цэврийн талаарх аян болон олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байсан байна. Дийлэнх сурагчид гар угаах дарааллыг цэцэрлэгт байхдаа сурсан байна (Зураг 42).



Зураг 42. Сургуулиас зохион байгуулсан сургалт, аян олон нийтийн үйл ажиллагаанд оролцож байсан эсэх %

Гарыг 30-60 секунд угаах ёстой гэж боддог нийт сурагчдын 30.3% сургуулиас зохион байгуулсан гарын ариун цэврийн талаарх сургалтад хамрагдаж байсан байна. Энэ нь бага ангийн сурагчдад сургалт, мэдээллийн хүртээмж бага, мөн сурагчид гар угаах зөв мэдээллийг цэцэрлэгт байхдаа болон эцэг эхээсээ түлхүү сурч авсан нь харагдаж байна.

Дэлхийн гар угаах өдрийг мэдэхгүй сурагчдын 69.5% сургуулиас зохион байгуулсан гарын ариун цэврийн талаарх сургалтад хамрагдаж байгаагүй байна. Харин 62.3% гарын ариун цэврийн талаарх аян болон олон нийтийн үйл ажиллагаанд оролцож байгаагүй байна. Тухайн тэмдэглэлт өдрийг мэдэхгүй байгаа нь сургалт, олон нийтийг хамарсан аяны үйл ажиллагааны зохион байгуулалт хангалтгүй болон сурагчдын хамрагдалт бага байгаатай хамааралтай байна. (Хүснэгт 34).

Хүснэгт 34. Дэлхийн гар угаах өдрийг мэдэхгүй сурагчид сургалт болон аян, олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байгаагүй сурагчдын харьцуулалт n,%

Дэлхийн гар угаах өдрийг мэдэхгүй сурагчдын тоо/хувь		Гарын ариун цэврийн талаарх сургалтад хамрагдаж байгаагүй сурагчид		Гарын ариун цэврийн талаарх аян болон олон нийтийн үйл ажиллагаанд оролцож байгаагүй сурагчид	
n	%	n	%	n	%
488	94.8	339	69.5	304	62.3

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

- 1) Сургуулиас зохион байгуулсан гарын ариун цэврийн талаарх сургалтад сурагчдын 31.5% хамрагддаг, насаар ангилж авч үзэхэд 6-8 настай сурагчдын хамрагдалт бусад насны сурагчдаас хамгийн өндөр байв.
- 2) Гарын эрүүл ахуй сахих талаар сурталчилгааны материал байдаг эсэхийг тодруулахад сурагчдын 37.1% сургуулийн орчинд, 37.9% ангид байдаг гэж хариулсан байна. Энэ нь анги болон сургуулийн орчинд мэдээлэл сурталчилгааны материалын хүртээмж ойролцоо түвшинд байгааг илтгэж байна.
- 3) Гар угаах дарааллыг мэддэг сурагчдын 38.9% сургуулийн орчинд, 42.5% ангид гар угаах мэдээлэл сурталчилгааны материал байдаг гэж хариулсан байна. Энэ нь сургууль болон ангиас гар угаах мэдээллийг авч, дарааллыг мэддэг болсон байх магадлалтай гэж үзэж байна.
- 4) Гар угаах дарааллыг мэддэг сурагчдын 36.3% сургуулиас зохион байгуулсан гарын ариун цэврийн талаарх сургалтад хамрагдаж байсан ба 21.4% гарын ариун цэврийн талаарх аян, олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцдог байна. Сурагчид гар угаах дарааллыг цэцэрлэгт байхдаа түлхүү сурсан байгаа нь сургуулийн өмнөх боловсролын байгууллагад зөв дадлыг хэвшүүлэх ажлын үр дүнтэй шууд хамааралтай юм.
- 5) Гарын ариун цэвэр сахих талаарх мэдээллийг сурагчид ихэнх тохиолдолд эрүүл мэндийн байгууллага болон найз нөхөд, гэр бүлээсээ авдаг. Энэ нь өдөр тутамд хийдэг дадлуудын нэг тул ойр дотны хүмүүсээс гарын эрүүл ахуйтай холбоотой мэдээллийг илүү авдаг байна.
- 6) Гарын ариун цэвэр сахих талаар мэдээ, мэдээллийг ямар хэлбэрээр авбал сонирхолтой талаар сурагчдаас тодруулахад 42.7% эмчээс, 14.8% сургалтаар, мөн интернэт, видео анимейшн зэргээс авах сонирхолтой гэж хариулсан байна. Иймд сурагчид мэргэжлийн эмч нарын зөвлөгөө мэдээлэлд илүү анхаарал хандуулж, зөвлөгөөг өдөр тутамдаа дадал болгох хандлага ажиглагдав.
- 7) Үнэлгээнд хамрагдсан сурагчдын 61% гарын ариун цэврийн талаарх аян, олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байгаагүй байна.
- 8) Гарыг 30-60 секунд угаах ёстой гэж боддог сурагчдын 30.3% сургуулиас зохион байгуулсан гарын ариун цэврийн талаарх сургалтад хамрагдаж байсан. Энэ нь бага ангийн сурагчдад сургалт, мэдээллийн хүртээмж бага, мөн сурагчид гар угаах зөв мэдээллийг цэцэрлэгт байхдаа болон эцэг эхээсээ түлхүү сурч авсан нь харагдаж байна.
- 9) Дэлхийн гар угаах өдрийг мэддэггүй сурагчдын 69.5% сургуулиас зохион байгуулсан гарын ариун цэврийн талаарх сургалтад хамрагдаж байгаагүй, харин 62.3% гарын ариун цэврийн талаарх аян, олон нийтийн үйл ажиллагаанд оролцож байгаагүй байна.

БҮЛЭГ 4. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

- Гарын ариун цэвэр сахих талаарх сурагчдын мэдлэг, хандлага сайн байгаа хэдий боловч сургуулийн орчинд гар угаах нөхцөл хангалттай бүрдээгүй байна. Гар угаах талаарх мэдлэг, хандлага, дадал нас ахих тусам буурч байгаа буюу 9, 10 настай сурагчдад харьцангуй бага байна.
- Сургуулийн орчинд гарын ариун цэвэр сахих талаарх мэдээлэл сурталчилгааны материалын хүртээмж хангалтгүй байсан бөгөөд энэ талаарх сургалт, олон нийтийн үйл ажиллагаан дахь сурагчдын хамрагдалт бага байна.

4.2. ЗӨВЛӨМЖ

БАГШ, ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

1. Анги танхим, ариун цэврийн өрөөг гарын савангаар тогтмол хангах
2. Гар угаах ач холбогдол, гарын ариун цэвэр сахих талаарх сурталчилгааны материалыг сурагчдад харагдахаар тохиромжтой газар байршуулах
3. Сурагчдыг үдийн хоол, цай идэхээс өмнө болон бие зассаны дараа гар угаах дадалд сургах
4. Гарын ариун цэврийг сахих талаарх сургалт нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах, сурагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэх
5. Эцэг, эхчүүд гэртээ гар угаах нөхцөлийг бүрдүүлэх, хяналт тавих, уриалах
6. Гар угаах ач холбогдлын талаар хүүхдэдээ ойлгуулах, үлгэрлэх

СУРАГЧДАД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

1. Гараа бохирдсон тухай бүрд савантай бүлээн усаар 20 секундээс багагүй хугацаанд угааж хэвших
2. Гарын ариун цэвэр сахих зорилгоор нойтон салфетка, гар халдваргүйжүүлэгч уусмалыг биедээ тогтмол авч явах, хэрэглэх
3. Гарын ариун цэврийн талаарх сургалт, аян, бусад нөлөөллийн ажилд идэвхтэй оролцох, манлайлах, бусдыг уриалах
4. Гарын ариун цэврийн талаарх албан ёсны мэдээллийг бусдадаа хуваалцах

ТАНИУЛСАН ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС

Таны энэ өдрийн амгаланг айлтгая.

Намайг гэдэг. Би ЭМЯ-ны харъяа Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв судлаач ажилтай. НҮБ-ийн Хүүхдийн сангийн дэмжлэгтэй зохион байгуулагдаж буй “НИЙСЛЭЛИЙН СУРГУУЛИУДЫН БАГА АНГИЙН СУРАГЧДЫН ГАРЫН ЭРҮҮЛ АХУЙН МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДЛЫГ ҮНЭЛЭХ” үнэлгээнд танай сургуульд явуулж байна. Үнэлгээнд 1-5 дугаар ангийн сурагчдыг төлөөлж санамсаргүйгээр та сонгогдсон байна. Судалгаанд нийт 540 сурагчдыг хамруулж асуулгаар хүн ам зүйн мэдээлэл, гарын эрүүл ахуйн талаарх мэдлэг, хандлага, дадлыг тогтоох мэдээллийг цуглуулна. Дээрх мэдээллийг цуглуулахад нийт 20-30 минутын хугацаа шаардагдана. Үнэлгээний үр дүнгээр сурагчдын гарын эрүүл ахуйг сайжруулах, түүнээс үүдэлтэй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга замыг сайжруулах, нотолгоог бий болгох, бодлого шийдвэр гаргагч нарт зориулсан зөвлөмж боловсруулах юм. Иймд таны өөрийн зөвшөөрлөөр үнэлгээнд оролцож бидний ажилд тусална гэдэгт итгэж байна. Та энэхүү үнэлгээнд оролцсоноор:

- Үнэлгээнд оролцсон урамшуулал олгоно.
- Таны үнэлгээнд оролцсон тухай болон танаас цуглуулсан мэдээллийн нууцыг чандлан хадгална.
- Мэдээллийг зөвхөн үнэлгээний зорилгоор ашиглах бөгөөд үр дүнг хэвлэлд нийтлүүлэх, тайлан бичихдээ таны нэр, хаягийг ашиглахгүй.
- Үнэлгээнд та сайн дураараа, өөрийн зөвшөөрлөөр оролцох бөгөөд үнэлгээнд оролцохоос болон үргэлжлүүлэхээс татгалзах, хүсэхгүй тохиолдолд асуултанд хариулахгүй байх эрхтэй.

Та дээрх мэдээлэлтэй танилцаж, үнэлгээний зорилгыг ойлгож байгаа бол зөвшөөрөн гарын үсгээ зурна уу. Хэрэв танд ойлгомжгүй асуудал байгаа бол үнэлгээний багийн ахлагчаас дэлгэрэнгүй мэдээллийг тодруулж болно. Би гарын үсэг зурснаар үнэлгээнд өөрийн хүсэлтээр оролцож байгаагаа илэрхийлж байна.

Сурагчийн овог нэр

Сурагчийн гарын үсэг 2024 оны сар өдөр

Өөрийн утасны дугаар:

Асран хамгаалагчийн утасны дугаар:

Бидний судалгаанд идэвхтэй оролцсон Танд талархал илэрхийлье.

Хавсралт 2

“НИЙСЛЭЛИЙН СУРГУУЛИЙН БАГА АНГИЙН СУРАГЧДЫН ГАРЫН ЭРҮҮЛ АХУЙН МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДЛЫГ ҮНЭЛЭХ” ТҮРГЭВЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ АСУУМЖ

АСУУЛГЫН ДУГААР [] [] [] [] []

Д/д	Асуулт	Хариулт			
1	Сургуулийн нэр/дугаар			
2	Судалгаанд оролцогчийн анги			
3	Судалгаа авсан огноо, сар өдөр	2024 оны сарынөдөр.....цаг.....минут			
4	Судалгаанд оролцогчийн хүйс:	1. Эрэгтэй 2. Эмэгтэй			
5	Судалгаанд оролцогчийн нас			
6	Та хаана амьдардаг вэ?	1. Гэр хороолол /Байшин, гэр/ 2. Орон сууц 3. Сургуулийн дотуур байр 4. Бусад 5. (Тодруулна уу) _____			
7	Ам бүлийн тоо			
МЭДЛЭГ (К)					
8	Гарыг хэзээ угаах хэрэгтэй (эсвэл хэрэггүй) гэж үзэж байна вэ?		Хэрэгтэй	Хэрэггүй	Мэдэхгүй
		Хоол хийхийн өмнө			
		Хоол идэхийн өмнө			
		Хоол идсэний дараа			
		Бие зассаны дараа			
		Гар бохирдсон үед			
		Гаднаас гэртээ орж ирсний дараа			
9	Гараа угаах дарааллыг мэдэх үү?	1. Тийм 2. Үгүй бол 10 руу шилжих 3. Мэдэхгүй бол 10 руу шилжих			
10	Гар угаах дарааллыг хаанаас сурсан бэ? /олон хариулттай байж болно/	1. Цэцэрлэгт байхдаа 2. Эцэг эхээсээ 3. Эрүүл мэндийн хичээлээс 4. Интернэт 5. Телевиз радио 6. Сургалт, сурталчилгааны материал 7. Аян, олон нийтийн арга хэмжээ			
11	Гарыг хэдэн минут угаах ёстой вэ?	1. 30 секунд хүртэл 2. 30 секунд- 1 мин хүртэл 3. Мэдэхгүй			
12	Гараа бүрэн угаахад саван шаардлагатай юу?	1. Тийм 2. Үгүй			

13	Дэлхийн гар угаах өдөр хэдэн сард болдог вэ?	1. ----- сар бичнэ үү 2. Мэдэхгүй бол 15 руу шилжих
14	Дэлхийн гар угаах өдрийн тухай хаанаас мэдсэн бэ?	1. Сургууль/Цэцэрлэг 2. Эцэг эхээсээ 3. Найз нөхөд 4. Интернет 5. Телевиз радио 6. Бусад (Тодруулна уу)
15	Гараа угаахын ач холбогдол юу вэ?	1. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ 2. Гар цэвэр харагдана 3. Ач холбогдол багатай 4. Мэдэхгүй
ХАНДЛАГА (А)		
16	Гар угаахад зөвхөн ус байхад хангалттай юу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй
17	Ханиалгаж, найтаасны дараа гараа угаах шаардлагатай юу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй
18	Бохирдсон гар бусдад халдвар дамжих эрсдэлтэй юу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй
19	Хэрэв гараа усаар сайтар угаасан бол саван хэрэглэх шаардлагатай юу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй
20	Гараа угаах нь халдварт өвчнөөс сэргийлнэ гэдэгтэй санал нийлж байна уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй
ДАДАЛ (Р)		
21	Өдөрт дунджаар хэдэн удаа гараа угаадаг вэ?	_____ удаа
22	Гараа угаахдаа саван хэрэглэдэг үү?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй
23	Өглөө гараа угаадаг уу?	1. Тийм 2. Үгүй бол 24 руу шилжих
24	Хэрэв тийм бол гараа хэрхэн угаасан вэ?	1. Савандаж, усаар угаасан 2. Зөвхөн усаар угаасан
25	Гараа угаахдаа хэдэн минут зарцуулсан бэ?	1. 30 секунд хүртэл 2. 30 секунд- 1 мин хүртэл 3. Мэдэхгүй
26	Сургууль дээрээ гараа угаадаг уу?	1. Тийм 2. Үгүй 3. Заримдаа
27	Сургууль дээрээ ямар тохиолдолд гараа угаадаг вэ? /Олон хариулттай байж болно/	1. Сургууль дээр юм идэхийнхээ өмнө 2. Бие зассаны дараа 3. Угаадаггүй 4. Гар бохирдсон үед 5. Завсарлагааны цаг бүрт 6. Бусад /Тодруулна/
28	Сургууль дээр байхдаа гараа хэрхэн угааж цэвэрлэдэг вэ?	1. Савандаж, усаар угаасан 2. Зөвхөн усаар угаасан 3. Гар халдваргүйжүүлэгч уусмалаар арчдаг 4. Нойтон салфетикаар арчдаг

		5. Угаадаггүй
29	Сургуулийн ариун цэврийн өрөөнд саван байдаг уу?	1. Тийм 2. Үгүй 3. Заримдаа
30	Сургууль дээрээ хоол идэхийн өмнө гараа угаадаг уу?	1. Тогтмол 2. Ихэнх үед 3. Заримдаа 4. Хэзээ ч угаадаггүй бол 31 руу шилжих
31	Хэрэв гараа угаадаггүй бол шалтгааныг тодруулна уу? /Олон хариулттай байж болно/	1. Усгүй байдаг 2. Савангүй байдаг 3. Сургуулийн 00-ийн өрөө хаалттай байдаг 4. Гар угаах цаг гардаггүй 5. Гараа угаахаа мартдаг 6. Гар угаах угаалтуур цөөхөн байдаг 7. Угаалтуур байдаггүй /эвдэрхий, ажилладаггүй...../ 8. Гараа угаах ёстой гэдгийг мэддэг боловч төвөгтэй санагддаг 9. Бусад (Тодруулна уу)
ГАРЫН ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА (МСА)		
32	Сургуулиас зохион байгуулсан гарын ариун цэврийн талаарх сургалтад хамрагдаж байсан уу?	1. Тийм 2. Үгүй
33	Танай сургуулийн орчинд гарын эрүүл ахуй сахих талаар сурталчилгааны материал байдаг уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй/санахгүй
34	Танай ангид гарын эрүүл ахуй сахих талаар сурталчилгааны материал байдаг уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй/санахгүй
35	Гарын ариун цэврийг сахих талаарх мэдээ, мэдээллийг хаанаас олж авдаг вэ? /олон хариулттай байж болно/	1. Эрүүл мэндийн байгууллагаас 2. Сургалт 3. Сурталчилгааны материал /Самбар, тараах материал 4. Телевиз/радио 5. Интернэт/Олон нийтийн сүлжээ (FB гэх мэт) 6. Гэр бүл, найз нөхдийн зөвлөгөө 7. Бусад 8. Мэдээлэл олж авч чаддаггүй
36	Гарын ариун цэврийг сахих талаар мэдээллийг ямар хэлбэрээр авбал үр дүнтэй, сонирхолтой вэ? /олон хариулттай байж болно/	1. Эмчээс 2. Сургалт 3. Сурталчилгааны материал/Самбар, тараах материал/ 4. Видео, анимейшн байдлаар 5. Эрүүл мэндийн клубийн үйл ажиллагаагаар 6. Телевиз/радио 7. Интернэт/ Олон нийтийн сүлжээ (FB гэх мэт) 9. Бусад
37	Гарын ариун цэврийн талаарх аян болон олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцож байсан уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй/санахгүй

Судалгаанд оролцсон танд баярлалаа.